



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2019.03.14, ПҮРЭВ ~ №047 (1099)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Лукашенко: Путиныг цус харвуулахад тун ойртлоо

Оросын зах зээлээс хэт хамаарахгүйн тулд худалдааны шинэ түншүүдийг хайдаг.

>4

737 Мах-ын осол Boeing-ын хувьцаанд түүхэн уналт авчрав

Дэлхий даяар 737 Мах-ын нислэгийг зогсоож байна.

>9

Төсвийн хөрөнгөөр лити агуулсан талбайг судалж, ялгах хэрэгтэй

Монгол орны хувьд кобальтын орд байхгүй, геологийн нөхцөл байдлаар ч үүсэх боломжгүй.

>11

ZGM DAILY

FULL ENGLISH PAGE INSIDE

>7

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Сайд Л.Оюун-Эрдэнэ утааг бууруулах ажлыг эрчимжүүлэхийг үүрэгдэв. **Эрүүгийн хэрэг хянан шийд-вэрлэх** тухай хуулийн зарим заалт ҮХ зөрчсөн гэж үзэв. **Ерөнхийлөгч зарлиг гаргаж Цэр-гийн түүхийн музейд** “Байлдааны гавьяаны одон” гардууллаа. **Ерөнхий сайд эзгүй тул** Засгийн газрын ээлжит хуралдаан хойшилжээ.

ЭДИЙН ЗАСАГ

Ажилтай боловч өөр ажил хайж байгаа 9.9 мянган иргэн байна. **Чанаргүй зээл нийт зээлийн** өрийн үлдэгдлийн 10.7 хувийг эзэллээ. **Засгийн газрын нийт өр 2018** оны эцэст 22.4 их наяд төгрөг болжээ. **Топ 20 индекс 0.82 хувиар** буурч, 20798.66 нэгжид хүрэв.



НИЙГЭМ

С.Амарсайхан: Цэнгээний газ-руудын зэрэглэл, ажиллах цагийн хуваарьт хязгаар тогтоох хэрэгтэй. **Маргаашаас шенгений визийн** материалыг Германы виз мэдүүл-гийн төвөөр дамжуулж авна. **Автобусан доторх камеруудыг** зургаадугаар сарын 1-нээс өмнө бүрэн ажилладаг болгоно. **Говьсүмбэр аймагт нүүрс угаах** үйлдвэрийн үйл ажиллагааг туршилтаар эхлүүлжээ.

ДЭЛХИЙ

Румыны худалдааны алдагдал тэрбум ам.доллараас давж, 10 жилийн дээд үзүүлэлт болов. **Үхэр шүтэх үзлийг хамгаалах** тухай Ерөнхий сайдын үг Энэт-хэгийн сонгогчдыг талцуулжээ. **Өмнөд Солонгост ажлын** байрны өсөлт 13 сарын дээд түвшинд ирсэн байна. **Европын аль ч улсад төрөлт** хангалтгүй учир цагаачид шаард-лагатай гэж Eurostat мэдээлэв. **Израйлын Ерөнхий сайд** Б.Нэтаньяху араб гаралтай иргэд жинхэнэ израилчууд биш гэжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2019.03.14

5°

-8°

ҮҮЛ БАГАСНА

ЦАГ АГААРЫН ДЭЛГЭЭНГҮЙ МЭДЭЭЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ.

8 6 5 8 0 0 0 0 2 9 1 1 2 0 1 0 9 9

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

ЭРДЭНЭТИЙН АСУУДЛААРХ 30 ГАРУЙ ШҮҮХ ХУРАЛ, ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДАРАА ЗГ ХЭЛЦЭЛ ХИЙХ Л ҮЛДЭЖ БАЙНА



Монгол Улсад ашигтай шийдэл гаргахыг хүсч байгаа бол Засгийн газар “Монголын зэс”-ийнхэнтэй хамт хэлэлцээрийн ширээний хоёр талд суухаас өөр сонголт үлдсэнгүй. ► 2

С.Батсайхан / ЗГМӨ

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Мэдлэггүй, мэдрэмжгүй, мэргэжилгүй мэргэжлийн хяналтын алба

Б.Энхжин
ЗГМ

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас УБТЗ-д шалгалт оруулахаар болсноо дуулиан-тайхан зарлаж, ажлаа эхлүүлээд байна. Монгол, Оросын хувь нийлүүлсэн компани гэсэн халхавч дор элдэв асуудлаас ямагт бултаж, бүтэхгүй бүхний “үүр” боллоо гэгдэх болсон “вант улс”-д шалгалт оруулах шийд-вэрийг олон хүн талархан дэмжсэн

нь гарцаагүй. Зөвхөн 2018 онд гэхэд төмөр замд нийт 62 осол бүртгэгдэж, ослын улмаас дөрвөн хүн амь насаа алдсаныг МХЕГ-ын төлөөлөл хэлж байв. Тиймээс нэлээд өргөн хүрээг хамарсан шалгалт болж, их ч зөрчил илрүүлэх байх гэсэн хүлээлт бий. Гэхдээ би энд шалгуулах гэж буй УБТЗ-ыг биш, шалгах гэж байгаа МХЕГ-ыг шүүмжилсэн хэдэн үг хэлмээр санагдаад болохгүй нь.

► 3

ЗГМ: СЭДЭВ

Мах идэх сайхан ч, мал ихдэх зовлон боллоо

Г.Билгүүн
ЗГМ

Монгол хүн мах идэхгүй удвал сэтгэл санаагаар унана. Их удвал хувьсгал ч хийж мэднэ. Хүн бүр өөхтэй хавирга огтлоод байдаггүй ч, малын тоо хорогдсон мэдээг монголчууд хамгийн мууд тооцно. Сүүлийн хэдэн жил улсын нийт малын маань тоо суга өсөж, сэтгэл цагталдаад сайхан гэж. Намар мах элбэгшээд идэш хийхэд ч урамтай. Гэтэл малын

тоо толгойг зориуд бууруулах “эсэргүү” бодлогын тухай сонсогдоод эхэллээ. Бүр мал аж ахуйн салбар хариуцсан яамныхан ийм бодлого баримталж байгаагаа зарлахад мал гэхээр мах идэхээ төсөөлдөг ахар бодолтой хүний дургүй хүрч байна гэж жигтэйхэн. Сонсох нь ээ, ХХААХҮ-ийн сайд Ч.Улаан ойрын хугацаанд малын тоо толгойг эрчимтэй бууруулах шаардлага тулгарсан тухай ярьж байна.

► 5

ЭДИЙН ЗАСАГ

ГШХО нүдний гэм болж мэдэхээр байна

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

Монгол Улсын хэмжээнд өнгөрсөн онд 1.8 тэрбум орчим ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгджээ. Үүний 90 хувь нь уул уурхайн салбарт орсон хөрөнгө оруулалт байна. Задалж үзвэл, “Оюутолгой” төслийн хоёр дахь шаг буюу гүний уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилт шууд хөрөнгө оруулалтын дийлэнх хэсгийг эзлэх аж. Эндээс нэг зүйлийг уншигч та анзаарсан байх. Монголыг чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт төрөлжиж чадаагүй, зөвхөн уул уурхайн салбар л хөрөнгө оруулалт татах хэмжээний өрсөлдөх чадвартай байгаа нь харагдана. Уул уурхай дотроо “Оюутолгой” төслийг эс тооцвол гадаадын шууд хөрөнгө оруулалт гэж асар бага тоо гарахаар байна.

Ходөө аж ахуй, аялал жуулчлал, сэргээгдэх эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт түлхүү татна гэж МАН-ын Засгийн газар зарласан. Гэвч өнгөрсөн оны хувьд авч үзэхэд дээрх салбарт хөрөнгө оруулалт нэмэгдсэн гэхээр онцлох дорвитой тоо, баримт алга. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл гэж шинээр байгуулсан нь багагүй ахиц боловч сүүлийн хоёр жилийн хугацаанд хөрөнгө оруулагчдаас гомдол, санал Үндэсний хөгжлийн газарт хамгийн их ирсэн байна.

► 12

ЗГМ: ИНФОГРАФИК

Boeing 737 Мах нислэгийг зогсоосон орнууд



АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	ХУРАЛДАЙ БОНД	ГЭРЭГЭ БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
1308.40 0.79%	6472 1.01%	98.700 0.13%	110.70 0.12%	99.330 0.12%	2634.73	391.30	39.13

Улс төр

Эрдэнэтийн асуудлаарх 30 гаруй шүүх хурал, дээд шүүхийн шийдвэрийн дараа 3Г хэлцэл хийх л үлдэж байна

3Г үндэсний хөрөнгө оруулагчийнхаа эрхийг зөрчиж ар-битрын өмнө очих уу

Б.Сэлэнгэ
ЗГМ

“Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийг төрийн мэдэлд авахаа мэдэгдэж, ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-Эрдэнэ тус үйлдвэрт онц дэглэм тогтоосон. Гэвч энэ нь Монголын Засгийн газрыг Олон улсын арбитрын шүүхийн өмнө унах бас нэгэн кэйс болоод байна. Засгийн газар энэ үйлдлээ УИХ-ын 23 дугаар тогтоолыг биелүүлж байна хэмээн хэлж буй нь үнэнээс хол зөрсөн тайлбар юм. Учир нь УИХ “Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийг төрийн мэдэлд авах асуудлаар хууль ёсны эзэмшигчидтэй нь буюу “Монголын зэс” корпорацитай хэлцэл хийх замаар шийдэхийг тогтоолоороо Засгийн газарт үүрэг болгосон. Харин Засгийн газар “хэлцэл хийх замаар төрийн мэдэлд авах” гэсэн УИХ-ын тогтоолыг зөрчиж, хүч хэрэглэсэн, хөрөнгө оруулагчийн эрхэнд халдсан, бизнесийн зарчмаар хандаагүйгээс уг асуудал дөрвөн шатны шүүхэд унаад байгаа



С.Батсайхан / ЗГМӨ

билээ. “Эрдэнэт” үйлдвэрт онц дэглэм тогтоож, прокурорын зөвшөөрөлгүйгээр шуугиан дуулиантай баривчилгаа явуулсны дараа “Монголын зэс” корпорациас Засгийн газартай хэлэлцээрийн ширээний ард суух хүсэлтийг хүргүүлсэн билээ. “Эрдэнэт” үйлдвэрт онц дэглэм тогтоох нь үйлдвэрийн хэвийн үйл ажиллагаа, цаашлаад Монгол Улсын эрх зүйт тогтолцооны хөгжил, хууль дээдлэх төрийн үйл ажиллагааны үндсэн зарчимд харшилсан таагүй туршлагыг үлдээнэ хэмээн “Монголын зэс”-ийнхэн үзсэн байна. Тиймээс тус компанийн зүгээс асуудлыг дотооддоо шийдэж, хэлцлийн ширээний ард сууя гэсэн хүсэлтийг Ерөнхий сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн юм. Хэрэв хэлцэл хийгдэлгүй, төр эрх мэдлээ ашиглан хувийн өмч

● **Өөрөөр хэлбэл Монгол Улсад ашигтай шийдэл гаргахыг хүсч байгаа бол Засгийн газар “Монголын зэс”-ийнхэнтэй хамт хэлэлцээрийн ширээний хоёр талд суухаас өөр сонголт үлдсэнгүй.**

● **"Эрдэнэт" үйлдвэрт онц дэглэм тогтоож, прокурорын зөвшөөрөлгүйгээр шуугиан дуулиантай баривчилгаа явуулсны дараа “Монголын зэс” корпорациас Засгийн газартай хэлэлцээрийн ширээний ард суух хүсэлтийг хүргүүлсэн билээ.**

● **Монгол Улс хөрөнгө оруулагчдын эрхийг зөрчсөн шалтгаанаар арбитрын шүүхэд очсон тохиолдлууд хэд хэд бий.**

рүү халдах нь асуудлыг Олон улсын арбитрын шүүхэд хүргэх сонголтыг л үлдээх нь тодорхой. Монгол Улс хөрөнгө оруулагчдын эрхийг зөрчсөн шалтгаанаар арбитрын шүүхэд очсон тохиолдлууд хэд хэд бий. Харамсалтай нь манай Засгийн газар дийлэнхэд нь унаж байсан юм. Гэхдээ арбитрт үүссэн маргаан бүхэн дандаа гадаадын хөрөнгө оруулагчидтай байгуулсан гэрээгээ зөрчсөн тохиолдол байсныг дурдъя. Тэр бүртээ манай улсыг бизнесийн найдвартай түнш биш гэсэн мессежийг гадаад орчинд өгч байлаа. Тэгвэл энэ удаа үндэсний хөрөнгө оруулагчдынхаа эрхийг зөрчсөн үндэслэлээр арбитрын өмнө очих ичгэвтэр жишээ рүү Засгийн газар түлхэж байгааг сануулах юун. Өөрөөр хэлбэл Монгол Улсад ашигтай шийдэл гаргахыг хүсч байгаа бол Засгийн газар “Монголын зэс”-ийнхэнтэй хамт хэлэлцээрийн ширээний хоёр талд суухаас өөр сонголт үлдсэнгүй. [ЗГМ]

» **ШАГНАЛ**
Ерөнхийлөгч Х.Баттулга Зэвсэгт хүчний 98 жилийн ой-Монгол цэргийн өдрийг тохиолдуулан Монгол Цэргийн музейг Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнах зарлиг гаргажээ. Уг зарлигийн дагуу Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд шагналыг гардуулж өглөө.

» **ИРЦ**
Ерөнхий сайд У.Хүрэлсүх Өмнөд Судан руу явсан тул Засгийн газрын ээлжит хуралдаан хойшиллоо. Ерөнхий сайдаас гадна салбарын хэд хэдэн сайд гадаадад ажиллаж байна.

» **ЦЭЦ**
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч дээд шатны шүүхэд гомдол гаргахад анхан шатны шүүхээс оноосон ялаас илүү хүнд ял оноодог. Ингэж эрх зүйн байдлыг дордуулж болохоор зохицуулсан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна гэсэн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн дүнд суудлын хуралдаанаас гаргалаа.

» **ХАРИЛЦАА**
Нийслэлийн Засаг дарга С.Амарсайхан АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Майкл Клеческийг хүлээн авч уулзав. Энэ үеэр Улаанбаатар хоттой ах дүүгийн харилцаат Денвер, Оакланд хотуудын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд дэмжиж ажиллахаа илэрхийлсэн байна.

ЭШЛЭЛ



“Эрдэнэт”-ийн санхүүгийн схем гэдэг нь мөнгө угаасан хэрэг юм гэж зарлаж байгаа. Мань хүн өөрөө хуульч биш байх л даа. Гэхдээ үүнийг санаатайгаар ийм гуйвуулга явуулж байгаа байх гэж харж байна. Хууль зүйн наад захын мэдлэгтэй хүн мөнгө угаах гэмт хэрэг гэж юу вэ гэдгийг мэдэж байгаа байх гэж бодож байна. Би арга ядаад Х.Нямбаатар нар Эрүүгийн хуулийг өөрчлөхдөө холион бантан хутгачихсан юм

болов уу гэж бодоод хуулиудаа эргэж харлаа. Мөнгө угаах гэмт хэргийн шинж нь гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө мөнгийг хэлнэ гэж байгаа. Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийг худалдаж авсан мөнгө нь гэмт хэргийн улмаас олдсон мөнгө байсан юм бол, түүнийгээ худалдаж авахаар ямар нэгэн хууль ёсны хөрөнгө оруулалт руу хийсэн бол энэ нь мөнгө угаах гэмт хэрэг юм. Монголбанкнаас авсан гэж байгаа мөнгө нь мөнгө

угаах гэмт хэрэг юм бол төвбанк мөнгө угаах гэмт хэрэг хийсэн байж таарах нь. Тэгэхээр цагдаагийн байгууллага болон Засгийн газар нь угаасаа энэ үйлдэлд огт хамаагүй өөр гэмт хэргийг хаяглаж мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн гэдэг байдлаар асуудал хөндөөд хуулийн байгууллага руу шидлээ гэж бодъё. Гэтэл тэнд хуулийн сургууль төгссөн хуульчид сууж байгаа учраас “энд мөнгө угаах гэмт хэрэг байхгүй байна, яагаад тэс өөр асуудлыг өөр гэмт хэргээр оруулж ирж байгаа юм бэ” гэнэ. Тэгээд шүүх ч юм уу, аль нэг хуулийн байгууллага нь “Энд мөнгө угаах гэмт хэргийн шинж алгаа” гээд хэлэхээр “Тэр МАНАН-гийн прокурорыг хар. Энэ муухай шүүгч, прокуроруудыг өөрчлөх ёстой” гэсэн улс төрөө хийхийн тулд бэлдсэн өөрсдийнх нь мухар гудамж юм биш үү. Хууль зүйн сайд асан Х.Тэмүүжин

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019.03.14-ний өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Компьютер, принтер, дэлгэц нийлүүлэх

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: ХО-2019/095

“ДЦС-4” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“Компьютер, принтер, дэлгэц нийлүүлэх”** цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул **www.tender.gov.mn** хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө **50.000 /Тавин мянган/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн жил тус бүрийн борлуулалтын орлого нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. 2017,2018 он тус бүрээр

2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.

3. Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: сүүлийн 2 жил. 2017, 2018он

4. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх /2017, 2018 он /

5. Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: Шаардлагагүй.

Тендерийн хамт **1,800,000 /Сая найман зуун мянган/** төгрөгний дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Хүчинтэй байх хугацаа: 2019 оны 06 дугаар сарын 28 -ний өдөр дуустал

Тендерийг **2019 оны 04 дугаар сарын 15-ны өдрийн 10.00 цагаас өмнө** цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 04 дугаар сарын 15-ны өдрийн 10 цаг 30 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй, Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, “ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 310 тоот өрөө Худалдан авах ажиллагааны хэлтэс
Утас: 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс: 7018-1309 7000-1357

Ирээдүйд ямар байх бол? Одоогийн нээлтүүд, судалгаа 2050 он гэхэд бидний өдөр тутмын амьдралд хэрхэн нөлөөлөх вэ?

ИННОВАЦ 2050

Даваа гараг /2019.03.18/

14:00

20:00 Даваа

22:00 Лхагва, Баасан

16:00 Бямба, Ням

Bloomberg TV Mongolia

Нийтлэлчийн булан

**Энэ байгууллага
жижиг ААН,
иргэдэд ямар
дээрэнгүй ханддаг
билээ**

Тэд сүүлийн таван жилийн турш УБТЗ-ыг шалгалт чадаагүй гэнэ. Нөгөөдүүл нь хоёр улсын хувь нийлүүлсэн компани, хоёр талын хамтарсан шалгалт оруулж болно гэж томроод халгаадаагүй байсан бололтой юм. Ингээд арга барагдахдаа салбарын сайдын тушаал гаргуулж байж шалгахгаар болжээ. Хэрэв сэтгэл байсан бол аль эрт дээд дарга нарынхаа дэмжлэгийг



ингэж ялгавартай ханддаг болохоор олон нийт мэргэжлийн хяналтынхныг шүүмжилж, үйл ажиллагаанд нь эргэлзээд байгаа юм.

Наад захын жишээ нь хотоор дүүрэн баригдсан чанаргүй барилгууд байна. Уг нь мэргэжлийн хяналтын байцаагчид хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй, осол гарах эрсдэлтэй барилга, үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагааг зогсоож, зөрчлийг арилгуулах ёстой. Гэвч энэ ажлаа хангалтгүй хийсний улмаас гудамжинд зүгээр алхаж байсан залуу барилгын төмөрт даруулж үхсэн тохиолдол хүртэл гарч байв. Одоо ч ийм аюул биднийг алхам тутамд отож байгаа. Өнгөрсөн зурч цэцэг цэврүү шиг бяхан үрс

Мэдлэггүй, мэдрэмжгүй, мэргэжилгүй мэргэжлийн хяналтын алба

авч, шалгалтаа оруулчих байлаа. Эртнээс шалгаад, алдаа дутагдлыг нь илрүүлсэн бол ингэж олон осол гарахгүй, эрдэнэт хүний амь үрэгдэхгүй байсан ч юм бил үү.

Ер нь мэргэжлийн хяналтын байгууллагын үндсэн үүрэг юу вэ. Тэд хамгийн гол нь дүрээр журам, норм стандарт, аюулгүй байдлыг шалгаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ёстой. Гэтэл манай хяналтынхан үй эсрэгээрээ, өнгөрсөн борооны хойноос цув нөмрөх арга хэрэгцээр өдийг хүрлээ. Энэ байгууллага ажлаа хангалттай хийгээгүйн улмаас Монгол Улс, Улаанбаатар хот ямар ч норм стандартгүй, хэзээ ч аюулд өртөж болзошгүй тэсрэх бөмбөг мэт болжээ.

Хамгийн сүүлд “Эко Алтан Заамар” компанийн уурхайд осол болж, дөрвөн хүн харамсалтайгаар амиа алдлаа. Осол болсны

дараа мэргэжлийн хяналтынхан “Бид энэ байгууллагад удаа дараа шаардлага хүргүүлсэн боловч биелүүлээгүй” гэсэн өрөвдөлтэй тайлбар хэлээд зогсох юм. Аюулгүй байдлыг хангах үүрэгтэй гол байгууллага нь ийм шүдгүй арслан шиг сул дорой байж болох уу. Үнэхээр хүч нь хүрэлцдэггүй жижигдээд байдаг юм бол холбогдох яам, хүчний байгууллагатай хамтраад арга хэмжээ авч болдоггүй юм уу гэмээр.

Хэвлэл мэдээллийнхэн ч та бүгдийг дуу нэгтэйгээр дэмжих болно. Гэтэл болохгүй байна, хүчрэхгүй байна гэсэн шалтаг тоочсоор өнөөг хүргэжээ.

Ослын газарт ажиллаад ирсэн Шадар сайд Ө.Энхтүвшин сэтгүүлчдэд “Мэргэжлийн хяналтын байгууллага ажлаа хийж байгаа. Гэхдээ тэнд очсон бүх хүн сайн ажиллаж байна гэж хэлэхэд хэцүү. Үзлэг хийчихээд

араас нь явдаггүй, хяналт тавьдаггүй нь үнэн” хэмээн мэргэжлийн нэртэй мэргэжлийн бус хяналтынхны бодит төрхийг тун товчоор дүгнэсэн байна лээ.

**Манай “сохор”
байцаагчид аюул
ослыг урьдчилан
харж чадаж
байгаа болов уу**

Түүнчлэн Одон орон, геофизикийн хүрээлэнгийн захирал С.Дэмбэрэл “Уул уурхайн үйл ажиллагаа явуулахад хөрс хуулахаас эхлээд газрын гүн дэх эрдэс баялгийг ухаж гаргахдаа орчиндоо эвдрэл үүсгэж байна. Энэ эвдрэл ямар аюул үүсгэж

байгааг аюулгүй ажиллагааны алба, мэргэжлийн хяналтынхан байнга хяналт тавих ёстой” хэмээн хэвлэлд өгсөн ярилцлагадаа онцолжээ.

Авлигатай тэмцэх газрыг хүмүүс жижиг жараахаатай л хөөцөлдөөд том тулыг нь барьж чаддаггүй хэмээн шүүмжилдэг. Тэгвэл МХЕГ-г бас энэ шүүмжлэлийг хангалаар байна. Үнэндээ энэ байгууллага жижиг аж ахуйн нэгж, иргэдэд ямар ширүүн, дээрэнгүй ханддаг билээ. Хэдэн дэлгүүр, цайны газар, ТҮЦ-үүдийг бол шалгаж, хааж боож, торгохдоо ёстой л уургын морь шиг ухасхийнэ. Түүнийгээ сүр дууллантай зарлахыг яана. Тэгсэн атал том байгууллагуын өмнө очихоороо ургаа хад мэт таг зогсчихно. Гэтэл энэ том газруудаас чинь л том осол, том зөрчил илрээд байна.

Ердөө ганц сарын өмнө KFC

сүлжээ ресторанаар үйлчлүүлсэн хүмүүс хоолны хордлогоос орж, олныг цочирдуулсан. Энэ өдрүүдэд нийт 242 хүнд хордлогын шинж тэмдэг илэрч, 44 хүн эмнэлэгт хэвтэн эмчүүлсэн. Үүнтэй уялдуулан мэргэжлийн хяналтынхан өнгөрсөн сарын 18-21-нд KFC-гийн салбаруудад шалгалт хийж байв. Дуулиант шалгалтаас хойш бараг нэг сар өнгөрсөн ч хариу нь гараагүй л байна. Шалгалтын хариу гаралгүй удах тусам хардлага төрүүлэх нь хэнд ч ойлгомжтой. Том байгууллага болохоор дүгнэлтээ гаргалгүй албаар удааж байна, тэдний нөлөөнд орчихож гэх хардлага эрчээ аваад буйг энд сануулья. Хэрвэ KFC шиг том сүлжээ биш, энгийн ресторанаас нийм зөрчил илэрсэн бол шалгалтын хариу нь ямар хурдан гарч, торгууль шийтгэлийг ямар хурдтай оноох байсан бол. Том, жижиг асвудад

зүгээр л тоглож наадаж байгаад өч төчнөөнөөрөө амиа алдлаа. Эцэг эхийнх нь харууслын нулимс хатаж амжаагүй л байна. Хэрэв зөрчил дагдгайгу илрүүлдэг, шалгадаг, арга хэмжээ авдаг байгууллага нь ажлаа сайн хийсэн бол энэ олон хүүхэд гэнэтийн ослын золиос болохгүй байв. Одоо урин дулаан цаг ирлээ. Хүүхэд багачууд гадаа тоглож, найзуудтайгаа ид бужигнах үе. Харин манай "сохор" байцаагчид аюул ослыг урьдчилан харж чадаж байгаа болов уу. Дахиад золгүй осол тохиолдсоны дараа сүр бадруулан давхиж очоод хаана, торгоно гээд явж байх вий дээ.

Урьдчилан сэргийлэх ажлаа
олигтой хийдэггүй, ниргэсэн
хойно нь хашгирах байдлаар
ажлаа явуулсаар ирсэн энэ
байгууллагыг, хэдэн байцаагч
нарыг нь яаж сэтгэлтэй, зүтгэлтэй
болгох вэ. [ЗГМ]

УХААРЛАЛ ХАЙРЛАХ УРАН ШОГ

Эхнэртээ арслан, эзэндээ хав



Судлаачийн үг

Лукашенко: Путиныг цус харвуулахад тун ойртлоо



Оросын зах зээлээс хэт хамаарахгүйн тулд худалдааны шинэ түншүүдийг хайдаг

Олхонуд Баярхүү
профессор

Би гэж хүн Белорусс судлаач эсвэл Лукашенко судлаач болж хувирах нь ээ. Түүнийгээ нотлох гээд хамт авхуулсан зургаа хүртэл дэлгэе.

Хуучин СССР-ийн геополитик судлах гэж мунгинаж явсаар нэг мэдэх нь ээ Белорусс руу халтирч орчоод болдоггүй. ОХУ-тай хамгийн гарамгай тоглож, араар нь тавьж, горьдоож, гомдоож, итгэл рүү нь ус цацаж янз янзаар аяглахыг нь харсаар бүр нэр оноож өгч чадахаа ч байлаа. Александр Лукашенко, Владимир Путин нарын удаа дараагийн уулзалтыг зурагтаар харж, сайтаас бичлэгийг нь үзээд нэг л зүйлийг олж харлаа. Путин нь гэнэн томоогүй хүүхдийн өхөөрдөм нүд, удаа бутарсан догдолсон царай, “Итгэж байна” гэх сэтгэлийн үгс, нөгөөх нь харах царайны том гарын дамын панзчин аятай, бие том, сөөнгө зэвүүн хоолойгоороо загнаад, тулгаад ч байх шиг, эелдэг дуугарна гэж ер байхгүй.

Үндэсний эрх ашгаа жинхэнэ дээдэлж чадаж байгаа улстөрчөөр Лукашенког би нэрлэх санаатай. Оросыг эцэст нь тултал мөлжье гэсэн бодлоготой байх шиг. Мөн Белорусс нь Оросын эдийн засгийн дайсагнагч топ 10 орны дотор байж байдаг. Мөлжүүлэхгүй гэмэгц нь Европын Холбоогоор айлгачихаад, одоо бүр ил цагаан



АНУ-аар шантаажилдаг болсон. Евразийн холбооны баруун чиглэлийн тэргүүн шугам гэсэн хаягийг Лукашенко өөртөө нааж, оросуудаа тэр имижээрээ айлгах санаатай. Оросын зах зээлээс хэт хамаарахгүйн тулд худалдааны шинэ түншүүдийг хайна, Хятад ба Африкт найдлага тавьж байна ч гэх шиг. ЕврАзЭС-д нэгдээд Белоруссын эдийн засагт өсөлт авчирсангүй хэмээн хэлээд авсан.

Холбооны улсын Төрийн Дээд Зөвлөл гэдэгтээ Москва онц их ач холбогдол өгнө. Холбооны хоёр улс нь ОХУ, БНБЕУ. Нэг орон зайд аажмаар хоёр улс нэгдэж нийлнэ гэх зорилгоор 1999 оноос ийм зөвлөл ажиллуулсан. Орос, Белорусс хоёрыг жинхэнэ холбоотон гэж үзнэ. Орост өөр яг 100 хувийн баталгаатай холбоотон байхгүй. Гэтэл Лукашенкогийн өнгөн дээр Белорусс нь Оросоос зөвхөн ашиг унагахыг зоринo. Нэгдэж нийлнэ гэж ярьчихаад цаашаа хараад эдийн засаг баларвал тусгаар тогтнолоо алдана хэмээн белоруссчуудаа айлгана. Белорусс ямар ч улсын бүрэлдэхүүнд орохгүй хэмээн зарлана. Маргаантай асуудал Оростой бишгүй байгаа, байх ч болно болоод явчихна. Оросоос нийлүүлдэг бараа бүтээгдэхүүн дээр Лукашенко байнга гонгиноостой. Өнө мөнхийн хоёр өстөн эвлэрэх нь үү гэмээр сүртэй мэдэгдэл хийнэ. Хилээ хаана, үндэсний аюулгүй байдалд нь заналхийлэх учраас Оросын цэргийн баазыг байгуулахгүй, НАТО-г дайсан гэж үзэхгүй, өрнөд ба Москвагийн хооронд гүүр болно гэдэ гадаад бодлого дээрээ нэг байран дээрээ хэд хэд хувирна. Үгээр тоглохыг үзүүлж өгнө.

Путинтэй уулзаж сүрлэг мэдэгдэл хийж, баримт бичигт гарын үсэг зурчихаад буцаж очоод Европын Холбооны санхүү, хүний нөөцийн комиссар Гюнтер Эттингертэй уулзаж үгтийн солиогүй л “Белорусс нь Европын Холбооны найдвартай түнш хэзээд байх болно, Брюсселийн зүгээс хоёр талын харилцаандаа ч ингэж хандана гэсэн итгэлтэй байна” гэх нь тэр. “Би бүр Та нарт батлан хэлье. Бүтэн хагас мянган километрээр хиллэдэг Белоруссынхаа чиглэлд Та бүхэн тайван амгалан байж болно” гэж байгаад ярьсан юм. Минск-Брюсселийн хооронд бид хамтдаа хол ахия. Бидний хооронд ужгирсан асуудал байхгүй гэж хэлэх нь ердөө нэг өдрийн өмнө Путинд батлан хэлж байснаас нь 180 градус эргэчихсэн.

Европын Холбоо руу эргэлээ, Брюссельд талтай болчихлоо гэж хардсанаас Орос-Украины харилцаа хурцдаад дипломат харилцаагаа таслахын босгон дээр тулж ирчээд байдаг. Гэтэл араас нь Белорусс аажим аажмаар барууншиж байгаа. Оросын геополитикийн эрх ашгийг арай л алж тавьж байх шиг.

ЕАDaily сайт дээр тооцоо гарчээ, бодвол эх сурвалжтай.

Орос энэ улстай найрамдлаа хадгалж, тойгдож байхын тулд 2018 онд долоон тэрбум ам.долларыг Белорусст тавиад туужээ. Хэт хямд үнээр газ, нефть нийлүүлж, харин Белорусс нь Оросоос авсан нефтиэ өөр тийш нь зарчихсан, найрамдлын өртөг нь энэ гэжээ. Гэтэл Лукашенко хээв нэг “Орос Белоруссыг тэжээгээгүй ээ” гэж хэлнэ.

ОХУ, БНБЕУ хоёр улсын өртөг нь 100 тэрбум ам.доллар гэсэн тооцоо Оросын хэвлэлд явж байна. “Холбооны үнэ цэнэ” Белорусс 20 жил Оростой нэгдэж байна. Үүнд нь тэрбум тэрбумыг гарзадлаа. Үр дүн үгүй гэсэн санаагаар Максим Семенов гэж тоймч зэвүүрхэн бичжээ. “Май, чиний тэр сайн холбоотон чинь” гэж гарчиглаад ёстой хэлэхгүй муухайгаар Лукашенког ялласан өөр нэг нийтлэл lenta.ru-д байна. Ингэн ингэн Белоруссыг тэжээж сэтгэлээ хуурах хэрэг байна уу гэсэн асуулга ил цагаан Путинд тавьжээ.

Эх орны дайны ялалтын баярын үеэр бүх Белоруссын бацька оросуудыг гомдтол нь гөвшөөд авсан. Эх орны дайны ялалтыг Орос өөртөө хувьчлах гэлээ гэх ял тохсон. Хилээ хаана, “хууль ёсны гэрлэлт”-ээ цуцлуулна гээд хийрхэж байсан чинь явж явж Эх орны дайны ялалтын талаарх маргаан бус нөгөөх нь Оросын газны үнийн сөргөлдөөн болж таарсан. Евразийн эдийн засгийн холбооныхоо хүрээнд өгөө аваа болоод өнгөрөхөд Орос л хохирч салдаг. Лукашенко-Путины ээлжит конфликт Оросын буулт хийлтээр шувтардаг. Эх орны дайн эхэлсэн ойн өдөр 2018 оны зургадугаар сарын 22-нд ийм нэг гарчигтай өгүүлэл оросууд тавьсан юм. “Лукашенко Оросыг сонгосонгүй, харин Европын Холбооны хувьд Белорусс нь транзит улс болоход бэлэн болжээ” гэсэн байв.

Белорусс нь Оросын эдийн засгийн дайсагнагч топ 10 орны дотор байдаг

“Независимая газета” сонинд хардлагын өгүүлэл байна. Белорусс нь Европын Холбоо руу ойртоод зогсохгүй, хэрэв Европ мөнгөөр тусална гэвэл улс төрийн реформ хийх гэж байна. Европын Холбооны хөршийн харилцаа, Европын Холбоог тэлэх яриа хэлэлцээ эрхэлсэн еврокомиссар Йоханнес Хан гэгчтэй уулзаад Александр Лукашенко ингээд хэлчихлээ. “Хашлага дээгүүр хэдэн биенээ харахаа больё, бид танай бизнест хэзээ ч саад хийж байгаагүй, одоо ч тийм. Бие биедээ зоригтой нээлттэй байя, дарамтгүйгээр, “Дорнод

түншлэл”-ийн стратегид заасан “Замын зураг”-аа дуусгая” гээд тэрбээр ярьжээ хэмээн Оросын тус сонинд цухалдангуй бичсэн байв. Шалтгаан нь нэн тодорхой. Бас л Лукашенко-Путины ээлжит конфликтын дараах тактик. Белоруссыг Европын Холбооны “Дорнод түншлэл”-д оролцуулахгүй гэснээс маргаан дэгджээ. Европтой худалдаа хийж чадахгүй байна гэж Минск цухалдах, цаашаа биш наашаа Евразийн Холбоо руугаа ханд хэмээн Москва цухалдах. Уг нь Холбооны нэг улс гэж Орос үзээд байгаа хэрэг шүү дээ.

Тэгтэл бүр хэтэрсэн алхмыг Лукашенко хийгээд эхэлжээ. “Белоруссын нутаг дэвсгэрт Оросын цэргийн бааз байх ёсгүй, Оросын цэргийн баазын хэрэгцээ ч алга” хэмээн Америкийн судлаачид ярьснаа өөр нэг уулзалт дээр “Европын үйл хэрэгт АНУ цэрэг-улс төрийн үүргээ хадгалах нь Европын бус нутаг, Европ тив дэх аюулгүй байдлаас хамааралтай”. Мөн “НАТО-той Белорусс яриа хэлэлцээ явуулахад нээлттэй, бэлэн байна”, “Тэнцвэрийг барих үүднээс, харилцаа тунгалаг байх үүднээс тэгэх нь дээр” хэмээн Белоруссын цэргийн дээд дарга нарын цугларалт дээр ярьсныг оросууд чухалгаж ядав. Гэтэл цаадах нь Гадаад хэргийн дэд сайд Олег Кравченко гэгчээ Вашингтон руу илгээж Атлантын Зөвлөлд үг хэлүүлэхдээ Оросын геополитикийн эрх ашгийг өм цөм эмтлэхээр мэдэгдэл хийлгэжээ. БНБЕУ-д ажиллах Америкийн дипломатчдын тоог нэмээч хэмээн уриалаад Белорусс нь Орос ба Өрнөдийн хооронд гүүрийн үүрэгтэй больё (10 жилийн өмнө Украин яг ингэж санал дэвшүүлж байсан), бүр хэтрээд Белорусст НАТО-гийн хэерийн сургууль явуулъя, нийгмийн сүлжээ, интернэтийн америк мэргэжилтнүүдийг урьж ажиллуулъя, НАТО Европын дорнод хэсэгт цэргээ байрлуулах, цэргээ тэлэхийг Белорусс нь аюулгүй байдалдаа учрах шууд аюул заналхийлэл гэж үзэхгүй гэхчлэн ярьсныг Москвад мэл гайхан хүлээн авав.

Алексей Макаркин гэх орос эрдэмтэн цухалдлаа барьж ядан бичжээ. Юу гэвэл, Москва Минскийг уучлахгүй талдаа болж байна. Өмнөд Осет, Абхазын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхийг гуйж тулгасан ч хөдлөөгүй, Крымыг Орос нэгтгэснийг хүлээн зөвшөөрүүлэх гээд бараагүй. Бас Европын Холбоо, Украинтай худалдаагаа нэмж байгаа нь оросуудад таалагддаггүй, Александр Зимовский гэж эрдэмтний бичсэнээр Кремльд Лукашенкогийн альтернатив гэж байхгүй учраас тэр нөхрийн элдэвлэхийг Москвад тэвчээд суухаас өөр аргагүй. Хэрэв сөрөг хүчин нь өндийх аваас тэр чигээрээ өрнөдийг баримжаалагчид байгаа учраас Лукашенког сонгохоос өөр

замгүй аж.

Гэтэл нөгөө Батька нь Путинд Белорусс улс хэзээ ч хэний ч вассал болохгүй гээд нотлоод байв. Тэгж ил тод зарласнаа ч бахархалтай ярина. Оросын хувьд Белорусс бол баруун руу харах хамгийн том цонх, тэгэхээр Орост тогтвортой Белорусс л хэрэгтэй гэнэ.

Оросыг эцэст нь тултал мөлжье гэсэн бодлоготой

Украины асуудал дээр Белоруссын байр суурь тун гомдмоор. Крымын статус, Донбасс дахь нөхцөл байдал дээр Минскээс төвийг сахих байр суурь хатуу баримталж буйг Гадаад хэргийн сайд Владимир Макей хэд хэдэн удаа зарласан. Албаны энэ мэдэгдэлд нь гоморхоод нэмэргүй. Харин Орос, Украины аль алинтай нь зэвсгийн наймаа хийгээд Украины байлдагч талуудыг зэвсэглэж, хөлсний цэргээ аль алинд нь алдчихаад сууж байгаад гомдмоор. Оросын news.gambler.ru гэх сайтад “Найдвартай найз” гэж гарчиглаад дэд гарчгаа “Донбасс байлдахад нь Украинд Лукашенко тусаллаа, харин Украины барааг Орост худалдлаа” гэжээ. Уншаад үзвэл итгэмээргүй баримтууд ярайна. Донбасс дайн дэгдмэгц нь мань Лукашенко энх тайвныг тохинуулагчийн үүргийг өөртөө авсан боловч бүр 2014 оны эхнээс Белорусс нь Украины армид зэвсэг, галт хэрэгсэл, техник, шатахуун нийлүүлсэн, Украины контрабандыг далдуур өөгшүүлсэн, энэ нь Белорусс маягийн нейтралитет (төвийг сахих) нь юм гэнээ хэмээн “Найдвартай найз” өгүүлэлд яллажээ. Киевт дэгдээд ялсан хоёрдугаар сарын тайвныг эргэлтийг Лукашенко тун тайван хүлээн авсан ба Янукович хөөгдөж буугаад, Крым Орост нэгдчихээд байхад Украины төрийн эргэлтийн тэр үеийн толгойлогч Турчиновтой уулзаж, Турчинов-Яценюкийн түр Засгийн газрыг Орост хууль гэж үзсээр байхад Лукашенко тэдний статусыг де-факто хүлээн зөвшөөрөөд Украины олон хэсэгт тувагдахыг эсэргүүцээд эхэлсэн.

Хүснээ “Бүхнийг фронтод” гэсэн аятай Украиныг зэвсэглээд эхэлсэн юм. Украинтай цэрэг-техникийн хамтын ажиллагаа тогтоож, Белоруссаас авсан орчин үеийн лут зэвсгээр нь Украины арми Донбаст байлдаж буй. Бүр захиалгаар нь зэвсэг техник үйлдвэрлэж нийлүүлж байна. Бидний сайн мэдэх МАЗ, КрАЗ заводууд Украинд зориулан армийн ачааны машин үйлдвэрлэж өгдөг болов. 2014 оноос хойш 900 байлдааны автомашин авчихаад

байна. Украины армийн танк, хуягтын аккумуляторын батарей, дуран авай бусад эд ангийг Белорусст бүтээж өгч байна. Ийм ажиллагааны үнэ хөлс сая сая доллараар хэмжигдэж, Белорусст орлого болж очдог гэхчлэн цэрэг-улс төрийн нэгдсэн бодлого командлалтай гээд байсан Белорусс чинь холбоотон Оросоо юу болгож тавьж байна даа. Тэгсэн хэрнээ энэ баримтуудыг Москвагаас гаргаж тавихаар Белоруссын цэрэг-аж үйлдвэрийн улсын хорооны дарга Олег Двигалев хэнэг ч үгүй бид төвийг сахисан статустай, яриа хэлэлцээгээ л хийж байя хэмээн оросуудаа тохуурхлаа гэхчлэн “Найдвартай найз” өгүүлэлд бичсэн байх юм.

Зэвсгийн наймаа бүр хорлонтой явагдсан өөр нэг баримт байна. Белоруссын тал Болгарын зуучлагч фирмээр дамжуулан танк эсэргүүцэх пуужингийн комплекс Америкт зарсан, тэр зэвсэг нь Америкийн тал баримтлагч Сирийн эрх чөлөөт армийн мэдэлд очоод нөгөөхөөр нь Оросын танк, хоёр ч нисдэг тэргийг сөнөөчихсөн нь оросуудын хувьд үнэхээр гомдмоор явдал биш гэж үү.

Оросууд бол бүр гомдмоор, харин белоруссчууд бол бахадмаар нь Оросын эсрэг цэрэг-дайны бэлтгэл хийж цэргээ сургуулиулж байгаа явдал хэмээн “Радио Крым”-ээр Белоруссын сөрөг хүчний төлөөлөгч Игар Тышкевич гэгч ярьсан байх юм. “Крымын сценар” ирж магад гээд Лукашенко армия бэлтгээд эхэлжээ. Оператив-тактикийн пуужингийн комплекс байршуулж, ард иргэддээ долоон сая автомат буу нөөцлөн ямар нэг “агресс”-ыг ёрлов. Хил залгаа орнуудаас нь хэн тэдэн рүү халдах вэ гэвэл Украин тэгэх манатай байгаа, Польш, Латви, Литва бол үгүй, Орос л үлдлээ хэмээн Игар Тышкевич ОХУ-ыг шууд харджээ. Лукашенкогийн ууган хүү Виктор Лукашенко гэж эцгийнхээ үндэсний аюулгүй байдлын зөвлөх, улс даяар сүлжээ бүхий тусгай ажиллагааны хүчний командлагчдын зохицуулах зөвлөлийн дарга нөхөр “Крымын сценар”-аас эх орноо сэргийлж байгаа болж таарчээ.

Үзэл суртлын талаар Батька маань юу холиож байгаа нь ч оросуудад эмзэг тусахаар. Зөвлөлт Холбоот Улсын тухай, Оросын түүх, Орос орны талаар сэтгэл дотно яриа дурсамжийг сэм сэмхнээр хавчиж, алга болгох, “Европын Беларусь” гэж арьдаг бичдэгүүд нь ял сонсохгүй чигтэй болж байна. Европын зүгээс Лукашенког шүүмжлэхээ ч больчихож. ЕАБХАБ-ын Парламентын Ассамблей Минскэд хуралдсан.

Белоруссын хөгжлийн концепцэд Орос, Европын Холбоо, Хятадыг нэг түвшинд авч үзэж байгаа аятай бүгдэд нь ач холбогдол өгөөд бүр Оросыг давж Хятадтай дорнын чиглэл баримтлах мэтээр бичжээ. Учир нь Белорусс нь Казахстан, Хятадаас Балтийн боомтууд руу очдог төмөр замын тээврийн “ачааны диспетчер”-ийн үүргийг өөртөө авчихсан. Үүндээ давуу эрх эдэлнэ хэмээн сайрхдаг, Прибалтик-Туркестан-Хятадын хооронд гүүр боллоо. Ингэхээр Европын Холбоо руу чиглэх хуурай газрын хамгийн сүүлчийн транзит цонх нь өөрсдөө гэв. Төмөр замын ачаа тээвэр дээр нэг мэдэхдээ Оросын төмөр замыг эвтэйхэн шахаад гаргачихжээ. Үнээ эрс хямдруулаад, харин ОХУ Прибалтик руу очих ачаа тээвэрлэлтийг стратегийн асуудал хэмээн томруулж үзээд хэрэг дээрээ Белорусс, Казахын төмөр замынханд мэхлүүлжээ. ОХУ ийнхүү олон тэрбумын хохиролтой хоцорлоо. Оросын судлаач Станислав Белковскийн үзэж байгаагаар Казахстан, Белорусс хоёр Оросоос алхам алхмаар сажж холдсоор, нэг мэдэхнээ Оросыг хорлоод дуусах юм байна. Крымыг Оростой холбосон алдарт гүүрийн нээлтэд Назарбаев, Лукашенко нар очоогүй, ерөөсөө Крым Оросынх гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа чинь л тэгж салж холдож байгаагийнх нь нотолгоо шүү дээ гэж ирээд Кремлээ сэрэмжлүүлжээ.

“Крымын сценар”-аас эх орноо сэргийлнэ гээд энэ мэт Оросыг ёстой хийж байгаа юм биш үү.


ЗГМ: Сэдэв

ХХААХҮЯ-наас малын тоог бууруулах бодлого баримтална

◀1

Бэлчээрийн даац хэтэрсэн л гэнэ, усны хангамж муудаж, хадлан тэжээл хүрэхгүй болсон, отрын бүс хумигдсан гээд түмэн зовлон тоочиж байна. Дээр нь царцаа, оготно хүртэл мал хорогдуулах үйлсэд “хүчээ өргөсөн” л гэнэ. Сайдын мэдээлэлд дургүй хүрсэн хүн шалтгааныг тодруулаад үзвэл уурлах бус ухаарваас зохилтой учир зүй олон байна.

Манай улсын мал сүргийн тоо толгой 1961-1991 онд хувийн өмчид очтолоо дунджаар 23 сая байжээ. Энэ нь социалист өмчид хайр гамгүй ханддаг байж гэхээс илүүтэй бэлчээрийн бодлого нарийн баримталдаг байсан гэх тайлбар зүүлттэй. Жишээ нь, 1980-аад оны хүн амын хүнсний хэрэгцээ, дотоодын боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эдээр тогтвортой хангах төлөвлөгөө гаргахдаа монгол орны бэлчээрийн даацын нормыг тогтоожээ. Түүгээр зун, намар 87.4 сая хонин толгой буюу таван төрлөөр 24 орчим сая мал, өвөл, хаварт үүнээс бараг хоёр дахин бага буюу 12 сая мал бэлчээрээр тэжээх бололцоотой гэж гаргаж байж. Үүнийг 1960-1970 оны 10 жилийн бүрэн хэмжээний судалгаагаар тогтоож ягштал баримталдаг байжээ. Гэтэл өнөөдөр 66 сая малыг хонин толгойд шилжүүлэхээр 110 сая болж байгаа юм. Маханд дуртай мань мэтгэд нь “их хоол л гоё” гэдэг шиг сайхан л сонсогдож байна. Гэвч судлаач, эрдэмтэд бэлчээрийн даац хэтэрсэн гэж салбарын яамныхныг шаналгасаар байгаа. Доктор С.Цэрэндаш тэргүүтэй эрдэмтдийн 2000 онд хийсэн судалгаанд “Өнтэй жил дунджаар 86 сая хонин толгой, харин гантай зун 57 сая мал бэлчээрээр тэжээх нь экологийн стандарт” гэсэн тооцоог яамныханд харуулж, анхааруулсан байна. Гэтэл өнөөдөр нийт 112.1 сая га бэлчээрийн 75 хувьд нь даац хэтэрсэн. Ядаж байхад яр гэгчээр бэлчээр талхалдаг гол буруутнаар тодорсон ямаан сүргийн тоо хониныхтой бараг ижил түвшинд очсон нь зовлонгийн бас нэг шалтгаан. Ямаа шимтэй өвсийг үндсээр нь иддэг учраас нөхөн төлжих боломжгүй болгодог годрон аж. Нэг ямаа гурван хоньтой тэнцэх



С.Батсайхан / ЗГМӨ

Мах идэх сайхан ч, мал ихдэх зовлон боллоо

хэмжээнд бэлчээрийг талхалдаг гэхээр “цамаан зантай”, царцуу махтай ямааг цөөрүүлэх нь зөв ч ноолуур өгдөг буянт мал гэдгээр нь хамгаалмаар ч шиг. Уг нь хөрснөөс цухуйж гарсан ургамлын 50 хувиас дээшгүйг малд идүүлж, үлдсэн хувийг хөндөхгүй үлдээж чадвал ургамал нөхөн төлжих чадвараа хадгалсаар байдаг тухай агрономчид сургамжилсан л байдаг. Агрономчийг агаар салхигүй хүлэмжид ажилладаг хүмүүс гэж ойлгодог өнөө үеийн малчдад энэ бараг хамаагүй санагддаг биз. Үүний хажуугаар өчнөөн зуун жилд хадгалагдаж ирсэн мал сүргийн зүй зохистой бүтэц алдагдах зэрэг бол хорь. гучдугаар асуудал. Хотоор дүүрэн хониныхоо сайндаа л хорин хувьд нь ямаа байлгадаг малчдын холч ухаан хэнд ч хэрэггүй болов.

Бэлчээрийн даац хэтрэх нь зөвхөн өвсний шим, ногооны гарцтай холбоотой юм биш. Мал нь өлсөхөөр майхнаа босгоод оторлох гээд гараад шидчихдэг малчид цөөнгүй. Отрын үед бэлчээрийн маргаанаас ах нь дүүгээ танихаа байтлаа муудалцах ч энүүхэнд. Өөр аймаг, сумын малчдыг “нүд үзүүрлэх”, хөөж, туух нь байдаг л үзэгдэл

ЗГМ: ИНФОГРАФИК



боллоо. Ялангуяа өвлийн улиралд “хил зөрчигч”-ийг хөөж явуулах кампанит ажил ундарч, зарга чирэгдэл засаг дарга нарын зовлонг бас нэмнэ.

Үүний дараа худаг усны хангамж зовлон нэмж эхэллээ. Орос ахын мөнгөөр худаг гаргаж, ус ундруулж байсан бид социалист нийгмийн үлдээсэн хөрөнгийг үрэн таран хийгээд малын усны хомсдолд оржээ. Худаг усны бригад гэгч хагарсан худаг, хатсан сайрын дэргэд дурсамж төдий л сөхөгдөж байна. Уг нь худаг гаргах зар Нарантуул захаар дүүрэн байх юм. Харамсалтай нь мянгат малчид нийлээд худаг гаргах, усны ундарга нэмэгдүүлэх ажлыг хийчих ухаангүй л сууна. Малаасаа зарцуулаад хөрөнгө мөнгө гаргах гэхээр мянгат биш болчих гээд байгаа учраас тэр биз. “Мал мянга хүрэхээр төхөөрөх төлгө олддоггүй” гэдэг энэ буюу. Худаг гаргах дээр нэгдэж чаддаггүй малчид хадлан тэжээл дээр ч яг ийм л байдлаар хандаж байна.

Өвөл болохоор хүйтэн болд-гийг төрийн түшээ нь хэлсээр байтал хадлангаа дутуу базааж, тусламж царайчилдаг малчид ч цөөнгүй. ХХААХҮ-ийн сайд ч малыг цөөлөхөөс аргагүй шалт-

гааны нэгэнд үүнийг дурдаж байна лээ. Тэрбээр “Улсын өвс-ний фонд, тэжээлийн нөөц “амь тарианд” хүрэлцэхээ больсон, жил бүр хангалттай бэлтгэх зорилгоор улсын мөнгө гамгүй зарцуулагдаж байна” хэмээн хэлсэн. Цаашид малчдын өмнөөс хадлан бэлтгэдэг өгдөг энэ шударга бус ёсыг халахад ч буруудахгүй. Өвс тэжээлийн тусламж авсан малчид намар улсын нөөцөд махаа хямдралтай өлдөггүйгээс хойш тэднийг эрхлүүлэх хэрэг юун.

Салбарын яамнаас малчдыг “эрхлүүлэхгүй” байх бодлогодоо шагналын асуудлыг ч хөндөж байгаа. Мянгат малчинд олгодог шагналын шалгуурыг өөрчлөх тухай яригдаж, тооноос чанарыг эрхэмлэнэ гэдгээ шууд хэлж байна лээ. Мал нь мянга давсан ч сүргийн бүтэц, ашиг шимээр маруухан бол засгийн шагнал мөрөөдөөд хэрэггүйг зарлаж байна. Бүр малынх нь тоогоор зээл олгодогийг өөрчлөхөөр банк, санхүү хариуцсан сайдаа хатгаж, ятгах гэнэ. Мөн олон жил ярьсан малын хөлийн татварыг батлуулахгүй бол малын тоо хорогдохгүй гэдгийг салбарын яамныхан хэлж байгаа. Ингэхээр мал ихдэхийн зовлон нэмэгдсээр байх бололтой.

Идэхийн жаргалд мал ихэдсэний зовлон үүгээр дуусахгүйг бас нэг жишээгээр өгүүлье. Малын тоо толгой ихсэх тусам газар тариалангийн талбай буурч байгааг ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулалтын газрын дарга Ц.Болорчулуун тоо баримт дурдан нотолж байна. Тэрбээр “Сэлэнгэ аймаг 1990 онд 300 мянган малтай байхад 340 мянган га-д тариалалт хийж байсан. Харин өнөөдөр 1.5 сая малтай болсноор тариалангийн талбай 300 мянга болж буурлаа. Ийм нөхцөлд газар тариаланг нэмэгдүүлэх боломж алга. Газар тариалан хөгжих боломжтой Архангай аймаг гэхэд л дарьгаараа таван сая гаруй малтай болсон” гэсэн. Үүнээс хэрвээ бид малынхаа тоог бууруулахгүй л бол гурилын хэмжээ ч нэмэгдэхгүй гэдгийг ойлгож цөхөх юмгүй.

Үүн дээр царцаа, үлийн цагаан оготно малын бэлчээр, газар тариаланд гай тарьж байгаа тоо баримт бий. 2018 оны байдлаар 40 сая га үлийн цагаан оготнод, 70 сая га царцааны нүүдэлд сүйдэж байна.

Мах идэх сайхан ч мацаг барьж сурахгүй бол... гэдэг зөвлөгөөг дээрх зовлон шалтгаан тодорхой санууллаа. (ЗГМ)

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2019.03.14

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Ус сувгийн удирдах газарт тос, тосолгооны материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах-2

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: УСУГ-БМ-2019-07

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендерт оролцогчдоос **тос, тосолгооны материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай битүүмжилсэн тендер** ирүүлэхийг урьж байна. Тухайн тендерт эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50,000 / тавин мянган /** төгрөгний цахим тендерийн хураамж төлж орлцоно.Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Сүүлийн 2 жил 2017, 2018 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ. Сүүлийн 2 жилд 2017, 2018 онд ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ. Тендерийн хамт 1,400,000 /нэг сая дөрвөн зуун мянган / төгрөгийн баталгаа ирүүлнэ. Хүчинтэй байх хугацаа: 2019 оны 06 дугаар сарын 27-ний өдрийг дуустал.

Тендерийг **2019 оны 04 дугаар сарын 15-ны өдрийн 11 цаг 00-аас** өмнө цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 04 дугаар сарын 15-ны өдрийн 11 цаг 30 минут-аас** нээнэ. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр, С.Чинбаатар Утас: 70157019-223

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2019.03.14

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Ус сувгийн удирдах газарт цахилгаан соронзон тоолуур, дагалдах хэрэгслүүд нийлүүлэгчийг сонгон шалгаруулах.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР/ГЭРЭЭНИЙ ДУГААР: УСУГ-ХА-2019-83

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендерт оролцогчдоос **цахилгаан соронзон тоолуур, дагалдах хэрэгслэлүүд нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай цахим** тендер ирүүлэхийг урьж байна. Тухайн тендерт эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50,000 / тавин мянган/** төгрөгний цахим тендерийн хураамж төлж оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 оны Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ. Сүүлийн 2 жилд буюу 2017, 2018 онуудад тухайн төрлийн гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ. Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онд тус бүр төсөвт өртгийн 100%-с дээш байх. Тендерийн хамт 2,400,000 /хоёр сая дөрвөн зуун мянган/ төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ. Хүчинтэй байх хугацаа: 2019 оны 06 дугаар сарын 27-ны өдрийг дуустал.

Тендерийг **2019 оны 04 дүгээр сарын 15-ний өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 04 дүгээр сарын 15-ний өдрийн 10 цаг 30 минут-аас** нээнэ. Гадаадын этгээд оролцох эрхгүй. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр, С.Чинбаатар Утас: 70157018-223

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 03 дүгээр сарын 13-ны өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:Төрөл бүрийн шибер нийлүүлэх

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: МС-29/2019

“ДЦС-4” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“Төрөл бүрийн шибер” нийлүүлэх тухай цахим тендер** ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул **www.tender.gov.mn** хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө **50.000 /тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: **1. Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн, жил бүрийн борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.,2017, 2018 он тус бүрээр **2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. **3. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 2017,2018 тус бүрээр /нотлох баримтын хамт/сүүлийн 2 жилийн дүн Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй гэрээт ажил гүйцэтгэсэн байна. Гэрээ дүнгэсэн баримт ирүүлнэ. Тендерийн хамт тендерт санал болгосон үнийн дүнгийн 2%-тай тэнцэх дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө. Тендерийг **2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 10.00 цагаас** өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 10 цаг 30 минутад** нээнэ. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй. Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрх тооцохгүй. Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, “ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 312, 313 тоот өрөө Худалдан авах ажиллагааны хэлтэс Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-13097000-1357

Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР



06.00	"Цагийн хүрд" мэдээллийн хөтөлбөр
10.30	Үл мэдэх ба түүний нөхөд
14.00	Технологийн ертөнцөөр
17.05	16 мм-ийн кино төсөл үзүүлж байна. "Нэг нарны хүмүүс"
19.30	"Хүрээлэн" амьд ертөнцийн цуврал
22.10	"Екатерина" Олон ангит уран сайхны кино 7, 8 дугаар анги



07.00	"Технологийн шийдэл" нэвтрүүлэг
08.00	"Bloomberg Daybreak Asia"
11.30	"Байршил" нэвтрүүлэг
14.00	"Сая долларын суутан" нэвтрүүлэг
20.00	#MadeInMongolia" нэвтрүүлэг
22.00	"PDAC-уул уурхайн хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт" тусгай хөтөлбөр

БОЛОВСРОЛ

07.05	Монголчууд ХХ зууны эхэнд нэвтрүүлэг
08.10	"Тобот" хүүхэлдэйн кино 1.15-16-р анги
11.20	"Хөгжилтэй Монголдой" 3-р ангийн хичээл №9
13.45	Би Монгол хүн
21.00	"Аяыг таа" шоу нэвтрүүлэг
23.05	"Нууц материалууд" ОАК 3.12-13-р анги
06.30	"Тог тог тог" /season-7/ 16-р хэсэг
11.40	Макс Стил хоёр" хүүхэлдэйн кино 41-р анги
13.30	"Ан амьтдын ертөнцөөр" / season-9/ 3-р хэсэг
16.00	"The Voice of Mongolia" шоу нэвтрүүлэг 14-р хэсэг
21.00	"Шивэгчний өчил" ОАК / season1/ 2-р анги
01.00	"Намайг сонгооч" / season1/ 3-2-р хэсэг

ЗУРХАЙ



Билгийн тооллын 8
Хаврын дунд улаагчин туулай сарын есөн улаан мэнгэтэй цагаан нохой өдөр
Үс засуулбал: Нас уртасна.
Наран ургах, шингэх: 07.07-18.54
Барилдлага: Хотол чуулган
Шүтэн барилдлага: Сансар
Суудал: Мод
18:28 цагт сар тал болно

Аргын тооллын гуравдугаар сарын 14, Бархасвадь гараг.
Билгийн тооллын 8, Гөрөөсөн толгой одтой, цагаан нохой өдөр.
Өдрийн наран 07.07 цагт мандан, 18.54 цагт жаргана. Тухайн өдөр бар, морь жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, хүүхэд үрчлэн авах, гэр, байшингийн суурь тавихад сайн. Эрдэнийг гадагш өгөх, нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийхэд муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Балжинямтай өдөр.

ОНЦЛОХ ҮЗВЭР

BOND 25



Жеймс Бондын шинэ цуврал "Bond 25" нэртэйгээр дэлгэцэнд гарна. Тус киног Кэри Фукунага найруулж, гол дүрд нь Дэниел Крейг тоглож байгаа аж. Харин ээлжит "Бондын бүсгүй"-гээр Францын жүжигчин Леа Сейду тодорсон байна. Оскарын наадмаас шилдэг эрэгтэй жүжигчний шагнал

хүртсэн жүжигчин Рами Малек удахгүй гарах "Bond 25" кинонд эсрэг дүрийг бүтээх гэж байгаа талаар Collider сэтгүүл мэдэгджээ. Өмнө нь киноны продюссерууд Рами Малекийг энэ дүрд тоглуулахаар хэлэлцэж байсан ч тухайн үед киноны зураг авалт "Mr. Robot" цувралын сүүлчийн улирлын хуваарьтай давхцаж

байсан аж. Харин одоо киноны продюссерууд киноны зураг авалтын хуваарьт өөрчлөлт оруулсан бөгөөд ингэснээр Рами Малек хоёр төсөлд нэгэн зэрэг оролцох боломж бүрдэж байгаа юм. "Bond 25"-ыг 2020 оны дөрөвдүгээр сарын 8-нд дэлгэцнээ гаргахаар төлөвлөж байна. [3ГМ]



"Монгол эрчүүд мандтугай" тоглолт
Хаана: Zaisan Hill Complex Event Hall
Хэзээ: 2019.03.16-нд
Тасалбарын үнэ: ₮160 мянга



Сонгодог хөгжмийн концерт
Хаана: Улсын филармони
Хэзээ: 2019.03.20-нд
Тасалбарын үнэ: ₮25 мянга



"Бүсгүйн зурвас" жүжиг
Хаана: УДЭТ
Хэзээ: 2019.03.01-нээс
Тасалбарын үнэ: ₮10-35 мянга

ЦАГ АГААР

УЛААНБААТАР




ФОТО АГШИН



Цас хайлж, цаг уяслаа.

С.Батсайхан / ЗГМ©

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

1		2		3	4	5
				6		
7	8		9	10	11	
	12	13		14	15	
		16				

БОСООГООР:

1. Хонь ямааг тогтооход хэлдэг үг

4. Хөвсгөл нутагт гаршуулан тэжээдэг буга
5. Сэнгэнэсэн амт үнэртэй зүйл
6. Нийслэл хотын

хөндлөнгөөр:

1. Хус модон дээр шимэгчлэн ургадаг эмчилгээний мөөг
3. Аав

7. Домогт жанжин Магсаржавын алдар цол
12. Говь-Алтай аймгийн төвийн хуучин нэр

Ф	А	Н	Т	А	О	Ш	И	М	А
О			О	Б	И			Р	
Т	Э	Д	Й	А	Х	О	Й	Г	
О			Р	А	Л	Л	И	А	
	Ч	У	У	Х	Х	У	Л		
Х			У	Ж	У			А	
У	Р	А	Л	А	Т	А	Г	Ш	
Л			Г	В	А			И	
С	А	Р	А	Й	А	Г	Л	А	Г

Өмнөх дугаарын хариу /03.13

ЗГМ: СУДОКУ

3		5	6	7				8
		8		9		2		1
		9	5					6
			4	5			9	7
			2	6		5		
						3	1	
	8				6			
	4				1			

2	6	3	7	9	1	5	8	4
1	5	8	6	3	4	7	9	2
7	4	9	8	2	5	3	1	6
9	3	1	4	6	7	8	2	5
4	7	2	9	5	8	1	6	3
5	8	6	2	1	3	9	4	7
3	1	4	5	8	6	2	7	9
8	2	7	3	4	9	6	5	1
6	9	5	1	7	2	4	3	8

(Өмнөх дугаарын хариу)

ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

МОСКВА-УБ	21.35	07.30
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
ЭРХҮҮ-УБ	15.35	06.20
УБ-СҮХБААТАР	21.15	05.12
СҮХБААТАР-УБ	20.55	05.03
УБ-ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ-УБ	19.10	05.48
УБ-ЗАМЫН-ҮҮД	17.20	07.05
ЗАМЫН-ҮҮД-УБ	17.35	08.55

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-БЭЭЖИН	08.15	10.30
БЭЭЖИН-УБ	11.30	14.00
УБ-ТОКИО	08.55	14.30
ТОКИО-УБ	15.30	20.25
УБ-БАНГКОК	16.35	21.55
БАНГКОК-УБ	20.55	
УБ-СӨҮЛ	07.40	12.00
СӨҮЛ-УБ	13.20	16.05
УБ-ХӨХ ХОТ	12.30	14.00
ХӨХ ХОТ-УБ	15.00	16.40

ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОВ

Батбаяр овогтой Баяртогтохын иргэний орлогын дэвтэр гээдүүлсэн тул хүчингүй болсонд тооцов.

February statistics show aggravating air quality in UB

The most harmful matter PM 2.5 jumped by 15 percent compared to last year.

Coal washing plant opens in Gobisumber province

The plant has an annual capacity of processing 1.5-1.8 million tons of coal.

Real wage stands 5 times lower than nominal wage, reports NSO

Analysts highlight the sluggish growth in the purchasing ability of the public.

Economic Situation and Trends - 2019 takes place

Economists express their views on solutions to the difficulties of sustainable economic growth.

ZGM: HIGHLIGHTS


POLITICS

Slovenia proposes to assemble ultralight aircraft in Mongolia.

Mayor of Ulaanbaatar city Amarsaikhan Sainbuyan meets the Ambassador of the United States to Mongolia Michael Klecheski, sharing views on broadening cooperation between the cities of the two countries. Ambassador Michael Klecheski expressed to focus attention on intensifying and developing relations with Mongolia which respects democracy and human rights and to work supporting the expansion of brotherhood relations of Denver and Oakland cities with Ulaanbaatar city.

ECONOMY

Top 20 Index decreases 0.82 percent, to 20,798.66 points. MSE A Index falls 0.08 percent, to 9,677.18 points. MSE B Index drops 0.3 percent, to 8,457.03 points. Market cap stands at MNT 2.48 trillion.



SOCIETY

Enerel Gombosuren claims bronze medal from the women's 71kg weight range of the World Youth Championships in USA, Las Vegas.

Deputy Prime Minister Enkhtuvsh Ulziisaikhan receives the Emergency Services staff, who worked at the crash site at Eco Altan Zaamar LLC.

Under the Japan Cooperation Program implemented by the Ministry of Health, the necessary equipment has been provided to the capital and local health organizations.

Second Central Hospital signs MoU on diagnosis and treatment equipment with the Korea Institute of Radiological and Medical Sciences.

MINING

Coal washing plant inaugurates in Gobisumber province

A coal washing plant located in Shiveegobi soum of Gobisumber province inaugurated recently. Set up by the Mongolian-Chinese joint venture Starto LLC, the factory has an annual capacity of processing 1.5-1.8 million tons of coal.

The plant is expected to provide 170-180 workplaces and a large proportion of the workforce will be generated locally after the plant begins operations. At present, the construction has been completed and the equipment will be installed within six months. Erdenes Tavan Tolgoi (ETT) is currently planning to utilize the factory to export washed coal to Asian and European markets.

As a result, Mongolia's coal is likely to take a step forward having an opportunity to enter the third market. It is also possible to wash lignite from Shivee-Ovoo mine, which supplies about 30 percent of Mongolia's domestic coal consumption, to increase the overall value. [ZGM]

PM2.5 in air increases by 15 percent yoy in February



Regardless of various air pollution reduction actions, air quality is growing worse in Ulaanbaatar city.

Batsaikhan.S / ZGM©

NSO reports increased particulate matters in the air

Aminaa.U
ZGM

Air quality in Ulaanbaatar is measured at 15 locations such as in ger areas, roads, residential

areas, and industrial districts. The statistics of February 2019 were presented by the National Statistical Office and the results are showing increasing particulate matters in the air.

The average concentration of pollutants in Ulaanbaatar during February 2019 compared to the same period of the previous year is as follows:

- PM2.5 particles increased by 15 percent to 0.016 mg/m3,
- PM10 particulate matter

increased by 24.4 percent to 0.038 mg/m3,

- SO2 sulfuric acid increased by 0.012 mg/m3 to 33.5 percent
- NO2 nitrogen dioxide decreased by 27.4 percent to 0.016 mg/m3.

The largest increase in sulfuric gas (SO2) means that "People with asthmatic bronchitis are more vulnerable to sulfur dioxide when they do physical work. The main effect narrows the respiratory tract and the symptoms are

Largest increase observed in sulfuric acid in the air, which is harmful to people with asthma

coughing and breathing with difficulty. Sulfur dioxide results in

physiological reactions such as sneezing and coughing. If the negative effects stop, lung function will be normal within an hour."

"Chronic sulfur dioxide affects respiratory illness, reduces lung protection mechanisms, and chronic cardiovascular disease. People with chronic cardiovascular disease and chronic lung disease, and children and the elder people are vulnerable to chronic exposure", warned authorities. [ZGM]

STATISTICS

Real wage stands 5 times lower than nominal wage

According to statistics, the real wage has increased five times less than the nominal wage in the last eight years.

Employees' monthly nominal salary was tripled in the fourth quarter of 2018 compared to the fourth quarter of 2010. Nevertheless, the real wage, which shows the purchasing ability, was up by 61 percent; however, the amount is five times lower than in 2010.

Experts concluded that purchasing power is not increasing enough. According to the corporate types of liabilities, the wage



Employees' monthly nominal salary was tripled in the fourth quarter of 2018 compared to the fourth quarter of 2010.

of state-owned enterprises was the highest in the fourth quarter of 2018 at MNT 1.3 million. The average salary of joint stock companies and limited liability companies stands about MNT 1.2-1.3 million.

However, the salary of public servants averaged at MNT 901.9 thousand and non-governmental workers' was MNT 885.1 thousand, which is lower than the rest. In general, the average monthly salary totaled MNT 1.1 million and the median salary was averaged at MNT 806,000. [ZGM]

OUTLOOK

Key stakeholders discuss obstruction to sustainable growth

Economic Situation and Trends - 2019 annual event took place yesterday. The conference involved the representatives of policymakers, researchers, media workers, students and the private sector in the economic and financial sector. They expressed their views on solutions to the difficulties of sustainable economic growth.

Experts reviewed the economic outlook, emphasizing that Mongolia needs to improve the situation with long-term external support. They also addressed the prolonging vulnerability of the economy, which is the mining-dependency. "The mining-driven economy can-

not be a long-term solution, and other sectors including agriculture and tourism should have the policy to raise foreign investments," according to a spokesperson of the World Bank Group.

Scholars warned that Mongolia is considered a high-risk country due to the current lack of foreign investments. It is necessary to create a state regulation to protect foreign investors from potential risks. If this stabilized environment is established, Mongolia will have the potential to increase its export revenue without depending on the mining industry. [ZGM]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СӨНИН II улирлын захиалга үргэлжилж байна



Онлайн захиалга

- Улиралд: 5000₮ (62 дугаар)
- Хагас жилд: 10 000₮ (124 дугаар)
- Жилд: 15 000₮ (248 дугаар)



Хэвлэмэл захиалга

- Улиралд: 30 000₮ (62 дугаар)
- Хагас жилд: 60 000₮ (124 дугаар)
- Жилд: 120 000₮ (248 дугаар)




Хосолмол захиалга (Хэвлэмэл + Онлайн)

- Улиралд: 32 000₮ (62 дугаар)
- Хагас жилд: 65 000₮ (124 дугаар)
- Жилд: 125 000₮ (248 дугаар)



Та доорх QR кодыг уншуулан гүйлгээний утга хэсэгт **и-мэйл хаяг, утасны дугаараа** бүртгүүлэн Засгийн газрын мэдээ сонинг өөрийн хүссэн хэлбэрээрээ захиалаарай.

QR код ашиглахгүйгээр төлбөр хийх бол:



2600092954

тоот дансанд мөнгөө тушаана уу.

zgm.mn

ZGMmn

zasagco

zgm.mn

70103131 99903581

Авто

Үзэсгэлэнгийн танхимын хамгийн үнэтэй машин 428 сая төгрөг

С.Батсайхан, С.Энэрэл
ЗГМ

Jaguar, Land Rover брэндийн Монгол дахь албан ёсны борлуулагч “Старчейз Авто-мотив Лимитед” ХХК Монголд анх удаа автомашины үзэсгэлэнгийн танхимтай боллоо. Энэхүү танхим нь 880 ам метр талбайтай бөгөөд 591 ам метр засварын цехийг нэмж барих юм байна. Тус компани энэ оны сүүлчээр зөвхөн Jaguar брэндэд зориулсан байнгын үзэсгэлэнгийн танхим бари-хаар төлөвлөж байгаа гэнэ. Энэ удаа үзэсгэлэнд заларсан автомашинуудтай танилцана уу. [ЗГМ]



ЗАГВАР: RANGE ROVER SPORT

Үйлдвэрлэсэн он: 2018
Ангилал: Автомат, механик хосолсон хурдны хайрцагтай, спорт ангиллын автомашин
Өнгө: Саарал
Дотор салон: Аюулгүйн зургаан камераар тоноглогдсон
Хөдөлгүүр: 3.0 литрийн бензин хөдөлгүүр, зургаан цилиндр, хос турбо
Хүчин чадал: 340 морины хүчтэй, есөн шатлалтай хурдны хайрцаг

Үнэ: **258** сая ₮

ЗАГВАР: JAGUAR F-PACE R-SPORT

Үйлдвэрлэсэн он: 2018
Ангилал: Спорт
Өнгө: Цагаан
Дотор салон: Улаан өнгийн тохилог зөөлөн бүрээстэй
Хөдөлгүүр: 3.0 литрийн бензин хөдөлгүүр
Хүчин чадал: 340 морины хүчтэй

Үнэ: **268** сая ₮



ЗАГВАР: JAGUAR XJ PORTFOLIO

Үйлдвэрлэсэн он: 2017 он
Ангилал: Тансаг зэрэглэлийн суудлын автомашин
Өнгө: Хар
Дотор салон: Модон болон арьсан оруулгатай, массажны тохиргоотой, бүх суудал халж хөрнө.
Хөдөлгүүр: 3.0 литрийн бензин хөдөлгүүр
Хүчин чадал: 340 морины хүчтэй

Үнэ: **345** сая ₮

ЗАГВАР: RANGE ROVER VOGUE SWB

Үйлдвэрлэсэн он: 2018
Ангилал: Тансаг хэрэглээний автомашин
Өнгө: Хар
Дотор салон: Аюулгүйн зургаан камераар тоноглогдсон
Хөдөлгүүр: Гурав болон таван литрийн багтаамжтай бензин хөдөлгүүр, автомат механик хосолсон, бүх замын гадаргуу мэдрэх системтэй
Хүчин чадал: 340-525 морины хүчин чадалтай, есөн шатлалтай хурдны хайрцаг

Үнэ: **428** сая ₮




С.Батсайхан / ЗГМ ©

Машины хулгайгаас сэргийлэх шинэ технологи

Г.Очирбат
ЗГМ

Ойрын ирээдүйд Toyota загварын автомашин хулгайлах гэж оролдсон этгээдийг таагүй зүйл отох магадлал ихсэв. АНУ-ын Патент, Худалдааны Тэмдэгтийн Алба Японы Toyota компаниас патент авахаар мэдүүлсэн Vehicle Fragrance Dispenser нэртэй технологийн мэдэгдлийг ил болголоо. Автомашины бүхээг дэх агаарт тансаг үнэртэн шүршдэг



Японы Toyota компаниас АНУ-ын Патент, Худалдааны Тэмдэгтийн Албанд гаргасан патентын мэдүүлгийн тайлбар зураг.

төхөөрөмжийн патентын мэдүүлгийг урьд нь BMW, Daimler зэрэг олон үйлдвэрлэгч авч байсан. Гэхдээ Toyota-гийн мэдүүлгийн санаа бусад үйлдвэрлэгчийнхээс өвөрмөц, үнэртэн шүршдэг системийг хулгайчаас хамгаалах зэвсэг болгох давхар зориулалттай. Ил болсон мэдээллээс үзвэл хэрэглэгчийн гар устай хоршиж ажилладаг автомашины цахим систем хууль ёсны эзэмшигчээ таньсан нөхцөлд өөрт нь таатай тансаг үнэр бүхээгт ханхалж байх юм. Патентын мэдэгдэлд

тайлбарласан санаагаар бол автомашины түгжээг хулгайч этгээд хууль бус аргаар тайлж, бүхээгт нэвтрэх тохиолдолд нүүр лүү нь нулимс асгаруулагч хий цацах юм. Одоогоор патентын мэдэгдэл төдий энэхүү санаа амьдралд хэрэгжиж чадах эсэхэд экспертүүд эргэлзэв. Тээврийн хэрэгслийн цахим системд бүртгэлгүй хэрэглэгч жолооны ард санаандгүй сууснаас болоод газдуулах эрсдэлтэй машиныг худалдан авах хүн хэр олон байх вэ гэсэн асуултыг шүүмжлэгч нар тавьж байна. [ЗГМ]

ЭДИЙН ЗАСАГ

Япон улс Toyota-г саран дээр буулгана

Toyota компани сансрын нисгэгч дотор нь ажиллах боломжтой сарнаа явагч бүтээж туршина.

> 10



Сингапурын хамтын оффис улам тансаг болж байна

Сингапурын Зууны цамхаг дахь Great Room компанийн хамтын оффисын байр жирийн нэг өрөө шиг харагдахаа больжээ.

> 10

737 Мах-ын осол Boeing-ын хувьцаанд түүхэн уналт авчрав

Жюли Жонсон

Ослын улмаас Засгийн газрууд
Boeing-ийн хамгийн борлуу-
лагдтай онгоцны нислэгийг
зоогоож байгаа нь компанийн
гүнзгий хямралд орууллаа.
Этиопын онгоц унасны дараа
ЕХ болон Энэтхэг 737 Мах-
ын нислэгийг цуцалсан хоёр
өдөрт эдний хувьцаа арван
жил үзэгдээгүй хэмжээгээр
доошижээ. Энэ сарын 10-нд
Индонезид мөн ижил төрлийн
онгоц сүйрч 157 хүний амийг
авч одооноос хойш тав хүрээгүй
сарын хугацаанд давтагдав.

Дэлхий даяар 737 Мах-ын нислэгийг зогсоож байгаа нь Воеинск компани ба АНУ-ын Холбооны агаарын тээврийн байгууллагаас гаргасан мэдэгдлийг үл хайхарсан хэрэг боллоо. Латин Америк, Африк, Ойрх Дорнодын орнууд хийгээд Хятад, Австрали хоригт нэгдсэний дараа Европын улсууд адил шийдвэр гаргасан нь тус компанид хүнд цохилт өгсөнөө байна. Jefferies фирмийн Лондон дахь шинжээч Сэнди Моррисс "Ийм үйл явц гайхалтай түргэн тархаж байна. Үүнийг харахад бараа АНУ-ын онгоцны эсрэг бослоо дэгдэв үү гэлтэй. Одоо Америкийн компаниудаас энэ онгоцыг ашигласан хэвээр үү гэж

асуумаар байна” хэмээв.

Этиопт хөөрөнгүүтээ унасан
737 Мах-ыг American Airlines
компаниуд ашигласаар байгаа.
Түүнчлэн Air Canada уг онгоцонд
итгэсэн хэвээр нисгэж байгаа авч
Европт хориглосон тул тийш
хийх хоёр нислэгээ цуцалжээ.
Мөрдөн байцаагчид Этиопын
онгоцны хар хайргаас мэдээлэл
авахаар ажиллаж буй. Нисэгчид
737 Мах онгоцон дээр нэмэлт
дадлага хийсэн гэж Ethiopian
Airlines-ын захирал телевизээр
мэдэгдсэн.

Индонезийн осолд онгоцны зогсолтын эсрэг программ нисэгчдийг гайхшруулж, унахын өмнө хэд хэдэн удаа хошууг доошлуулж байжээ. Уг программ нисэгчийн оролцоогүйгээр нэг мэдрэгчийн буруу дохиогоор ажиллаж, уналтыг зогсоох ямар оролдлого амжилтад хүрээгүй аж. Boeing ба АНУ-ын Холбооны агаарын тээврийн байгууллага, Этиопын ослын шалтгаан байж болзошгүй зогсолтын эсрэг программ болон буруу мэдрэгчийг солихоо зарласан байна. Онгоцны аэродинамик зогсолтыг үнэлдэг ганц мэдрэгчийн оронд хоёр мэдрэгч суулгах ажлыг ойрын долоо хоногт эхэлнэ.



Иймэрхүү маргаан хэлэлцүүлгийн завсар Ерөнхийлөгч Трамп “Онгоц нисэхэд хэтэрхий төвөгтэй болж байна”

хэмээн твиттертээ бичжээ. Дараа нь тэрээр Boeing-ийн захирал Деннис Мюленбергтэй ярьсан байна. Цагаан ордны

хэвлэлийн төлөөлөгч Сара
Сандерс Fox телевизээр ярихдаа
Ерөнхийлөгчийн хэлснийг
дэлгэрүүлж “Технологи

нисэгчдийн эрх мэдлийг хэт
булааж байгаа тус салбарынхан
сэтгэл түгшин ярьдгийг бид
мэднэ” хэмээн өгүүлжээ.

Индонезийн сонгуулийг орос, хятадууд хакердлаа гэв



iPhone-ы эрэлт бүр муудаж байгааг судалгаа харуулав



Карлис Сална

Хятад ба Оросын хакерууд Индонезид удахгүй болох Ерөнхийлөгчийн сонгуулийг тасалдуулахын тулд сонгогчдын мэдээллийн сан руу дайралт хийлээ гэж тус улсын сонгуулийн комиссын тэргүүн Ариёф Будиман мэдэгджээ. Индонезид ирэх сарын 17-нд Ерөнхийлөгчийн ба парламентын сонгууль зэрэг болно. Тэрээр зарим дайралт хоёр улсаас гаралтайг нотлоод мэдээллийн сангийн агуулгыг засах, хуурамчаар оруулах замаар байхгүй сонгогчийг нэмж оруулах оролдлого хийлээ гэсэн байна. Сонгуулийн комисс түүнчлэн Ерөнхийлөгчид нэр дэвшигч Прабовогийн сурталчилгааны баг сонгогчдыг хууран мэхлэх оролдлого хийснийг шалгаж байгаа гэжээ.

Райан Властелика

Apple компани iPhone утасны эрэлт ялангуяа Хятадад буурсан асуудлыг шийдэхгүйг оролдож буй. Гэвч Longbow Research судалгааны фирмийн тандалтаас үзэхэд байдал муугаас бүр муу руу чиглэж байгаа аж. Шинжээч Шон Харрисон "iPhone-ы эрэлт өсөх төлөв үзэгдэхгүй байгаа тул ойр эрд үүнийг дээшлүүлэх хүчин зүйлийг бид олж харахгүй байна" хэмээв. Уг загварын ухаалаг утасны борлуулалт дээшлэхгүй байгаа учир энэ сарын 25-нд болох үзэсгэлэн дээр Apple видео программын үйлчилгээ, сэтгүүл захиалгын апп танилцуулах гол анхаарлаа төвлөрүүлэх аж. Гэхдээ тус компанийн хувьцааны үнэ бага багаар дээшилсээр байна.

Т.Мэйн Брекситийн төлөвлөгөө дахиад нурлаа

Тим Россо

Британийн Ерөнхий сайд Тереза Мэйн боловсруулсан Брекситийн гэрээ парламентаар дахиад батлагдсангүй. Ийм нөхцөл тус улсыг улс төрийн хямралын ангал руу түлхэж, Европын холбооноос гарах үйл явц хойшлох, магадгүй буцаж магадгүй боллоо. Даваа гаргийн шөнө хүрл болтол хэлэлцэж, санал хураахад гишүүдийн 391 гэрсний сүүлийн хувилбарыг эсэргүүцсэн бол 242 нь эсэргүүцээ.

Ерөнхий прокурор Жеффрис Соксын шүүмжлэл эсэргүүцэгчдийн байр суурийг бататгах санал байна. Тэрээр ярилцагдаа Британийг ЕХ-ноос гаргах эцсийн огноо энэ сарын 29-нөөс хойшлогдох нь гарцаагүй байсан гэжээ. Парламент энэ долоо хоногт Брекситийг хойшлуулах асуудлаар санал хураалт явуулж, Мэйн Засгийн газарт төлөвлөгөөг дахин хэлэлцэх төлөв үүслээ.

байна. Гэвч энэ нь хямралыг дахин хэдэн сар сунгахаас цаашгүй гэх эргэлзээ төрүүлж буй. Тэрээр парламентаар хэлэлцэх боломжуудын дотор Брекситийн санал асуулгыг улс орон даяар дахин явуулах шийдэл бийр болохыг үгүйсгэсэнгүй. Ерөнхий сайд “Тэрээгүйгээр гарах болон хугацааг сунгах талаар парламентын санал хураалт бидний өмнө тулгарсан асуудлыг шийдэхгүй. Миний бодлоор, Британи ЕХ-ноос гэрээ байгуулан эмх цэгтэй гарах нь хамгийн зөв алхам. Бидний зөвшилцсөн гэрээ хамгийн сайн хувилбар бөгөөд одоо байгаа цорын ганц баримт бичиг” хэмээн тайлбарлав.

ЕХ-ны Ерөнхийлөгч Дональд Тускын хэвлэлийн төлөөлөгч хэлэхдээ саяын санал хураалт Британи холбооноос гэрээгүй гарах эрсдэлийг нэмэгдүүлээ гэжээ. Тэрээр “ЕХ хугацааг сунгах талаар Британийн санал авч үзнэ. Гэхдээ үндэслэлтэй шалтгаан болон тодорхой хугацаа байх ёстой” хэмэсэн байна. Хямралаас хямрал руу

явж байгаа хатагтай Мэйн албан тушаал одоо урьд урьдаас илүү эрсдэлд орлоо. Тэрээр миний төлөвлөгөөг няцааж, холбоотой нэгт харилцаатай хэвээр үлдэх нөхцөл рүү шахвал парламент 2016 оны бүх нийтийн санал асуулгын үр дүнгээс урвасан хэрэг болно гэж анхааруулж байсан.

Брекситийг дэмжигчид Ерөнхий сайдын төлөөлөгчөө Британийг холбооноос гарснаас дор ЕХ-нд уяна хэмээн болгоомжилж буй тул эсэргүүцсэн аж. Харин гарахаас татгалзах талынханд найдвар төрүүлж эхлэв. Гарах үйл явц дуусахад 10 гаруйхан хоног үлдээд байхад улстөрчид жилийн өмнөх асуудал дээр гагцхаад байна. Энэ нь Ирланд болон Британийн хил дээр гаалийн шалган нэвтрүүлэх боомт байх шаардлагатай эсэх тухай маргаан юм. Гаалийн хяналтгүй бол Британи хэзээ ч ЕХ-ны худалдааны дэглэмээс гарч чадахгүй гэж Брекситийг дэмжигчид шүүмжилж байгаа юм.

PREMIUM
BUILDING MATERIALS

ТӨГС БҮТЭЭГЧ 2019

БАРИЛГЫН САЛБАРЫН
ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ,
МЕНЕЖМЕНТ

SHANGRI-LA
HOTEL **2019.03.22**

Барилгын салбарын технологийн дэвшил, менежментийн талаар мэдээлэл солилцох “ТӨГС БҮТЭЭГЧ-2019” арга хэмжээнд бизнес эрхлэгч, бүтээн байгуулагч, удирдах ажилтан таныг хүрэлцэн ирэхийг урьж байна.

☎ 7777-3311

Технологи



JAXA, Toyota хэрэгжүүлэхээр судалгаа хийж буй концепт төслийн загвар.

Япон улс Toyota-г саран дээр буулгана

Рид Стивенсон
JAXA буюу Японы Сансрын Судалгааны Агентлаг хоёр зорчигч тээвэрлэн 10 километрийн зай туулах чадвартай зургаан дугуйт автомат жолоодлоготой өөрөө явагч хэрэгсэл бүтээхэд тус улсын автомашины тэргүүлэх үйлдвэрлэгчтэй хамтрахаар шийдлээ. Хамтран ажиллагч хоёр тал шинээр бүтээх тээврийн хэрэгслээ 2029 он гэхэд сарнаа буулгахаар төлөвлөж байна. Цахилгаан автомашин үйлд-

вэрлэгч Tesla Inc-ийг хамтран үндэслэгч Илон Маскийн SpaceX компанийн сансрын хөлөг Олон Улсын Сансрын Станцад амжилттай холбогдсоноос хойш долоо ч хоноогүй байхад дээрх мэдээлэл гарлаа. Сарнаа явагч төхөөрөмжийг эрчим хүчээр хангах Toyota-гийн fuel cell буюу шатахууны элементийн технологи нь хоёр сансрын нисгэгч тээвэрлэхэд хангалттай хүрэхүйц чадалтай. Сансрын нисгэгчид сарны гадаргыг судлан

шинжлэнгээ явагч төхөөрөмж дотор өмсгөлөө тайлж, дотор нь амьдрах боломжтойг Toyota-гийн дэд ерөнхийлөгч Шигэки Тэраши тайлбарлав. “Онцгой аз туршсан энэ төслийн хувьд бид Toyota-гийн технологид гол найдвараа тавьж байгаа” хэмээн NASA-гийн Space Shuttle хөтөлбөрөөр сансарт ниссэн, Олон Улсын Сансрын Станцын анхны япон удирдагч Коичи Ваката JAXA-гаас зохион байгуулсан арга хэмжээн дээр

мэдэгдлээ. Айл гэрийн ажил үүрэг гүйцэтгэх, алхаж чаддаггүй бэрхшээлтэй хүмүүст туслах зориулалттай роботууд бүтээх ажилд олон жилийг зориулсан Toyota компани үүсгэж хөгжүүлсэн технологио сансрыг эзэмших ажилд зориулах гэж байна. Toyota-JAXA-гийн сарнаа явагч тээврийн хэрэгсэл нь хоёр микро автобус нийлүүлэнтэй тэнцэхүйц буюу зургаан метр урттай, хүн амьдарч ажиллах багтаамж нь 13 шоо метр

байх юм. Өөрөө явагч төхөөрөмж нарны панель ашиглан эрчим хүч үүсгэж, үүсгэсэн эрчим хүчээ шатахууны элементийн зай хураагуурт хадгална. JAXA уг тээврийн хэрэгслийг түрүүлж саран дээр буулган, хүмүүсээс бүрдсэн судалгааны баг буух үед нь тосож авахаар тооцоолжээ. Төслийн дагуу өөрөө явагч төхөөрөмжийг судалгааны өөр дөрвөн бүсэд ашиглах юм. Сансрын судалгаанд жилд

найман тэрбум ам.доллар төсөвлөж АНУ-ын дараа дэлхийд хоёрдугаарт ордог БНХАУ-ын сарны амбиц идэвхжиж буй үед Япон улс дээрх мэдээллийг гаргаж байна. Энэ нэгдүгээр сард сарны нөгөө талд хүн төрөлхтний түүхнээ анх удаа газардсан дэлхийн хоёр дахь гол эдийн засаг сансарт нарны цахилгаан станц байгуулах төлөвлөгөөтэй. Тус улс энэ арван жилийн эцсээс өмнө Ангарагт гарагт өөрөө явагч төхөөрөмж газардуулахаар төлөвлөж байна.

Сингапурын хамтын оффис улам тансаг болж байна

Катрина Николас
Сингапурын Зууны цамхаг дахь Great Room компанийн хамтын оффисын байр жирийн нэг өрөө шиг харагдахаа больжээ. Гантиг шал, алтлаг эмжээр, хөргөгчинд нь жимсний ундаа гээд бүх юм бий. Энэ бүхэн тус салбарын арай жирийн үйлчилгээнээс шат ахисан хэрэг бөгөөд үнэ ч мөн дагаад дээшилсэн байна. Компанийг үндэслэгч, ерөнхий захирал Жэллэ Ан манай үйлчлүүлэгчид арай илүүг эдлэх боломжтой хэмээв. Great Room саяхан Raffles зочид буудалтай гэрээ байгуулснаар хотын дөрвөн байрлалд оффисоо нээлээ. Зургаан одтой буудалд нээх анхны хамтын ажлын байр нь 1400 шоо метр талбай эзлэх ба засвар хийсний дараа ажиллаж эхэлнэ. Тус компанийн байнгын хэрэглэгчид эдний оффисын орон



зай ашигласны хөлсөнд сардаа 1840 ам.доллар төлдөг. Энэ нь WeWork-ын үнээс 20 хувь дээгүүр боловч манай үйлчлүүлэгчид илүү тусгаар, аюулгүй, чимээгүй, сайн тавилгатай орчинд ажиллах боломжтой гэж хатагтай Ан ярив. Raffles-ын оффис үүнээс ч үнэтэй болох аж. Тэрээр цааш нь “Бид 18 настай залуус биш амжилттай яваа 45 хүрсэн мэргэжилтнүүдийг онилж, бизнесээ эхлэхэд тусална. Ийм төрлийн хүмүүст теннисний ширээ, хөнгөн тавилга шаардлагагүй. Тэд дээд зэрэглэлийн ажиллах орчныг хүсдэг” хэмээв. Great Room байнгын үйлчлүүлэгчдийг татах арга барил боловсруулжээ. Ан хэлэхдээ эднийх Raffles зочид буудалд ажилтнуудаа байрлуулдаг компаниудтай гэрээ хийхээр төлөвлөж байгааг тэмдэглэв. Тэд төлбөрийн

чадвартайгаас гадна ийм түүхэн барилдаг байрлах нь нэр төрийн хэрэг аж. Сингапурын уян хатан ажлын байрны зах зээл 2015 оноос хойш гурав дахин өссөн бөгөөд хамтын оффисоор үйлчилдэг компаниуд хотын төвийн А зэрэглэлийн барилгуудын гол түрээслэгчид юм. Олон улсын компаниуд уламжлалт төв оффисын зэрэгцээ уян хатан ажлын байр хайх болжээ. Bloomberg-ийн үл хөдлөхийн шинжээч Патрик Вон “Хамт ажиллах, тусдаа үйлчилгээтэй оффисын шинэ брэндүүд байнгын хэрэглэгчтэй болж байна. Эндхийн гишүүнчлэл авснаар орон зай болон харилцааны давуу боломж олж авдаг. Гэхдээ өнгөрсөн жил Азид энэ зах зээл хүчтэй тэлсэн учир 2019 онд тогтворжиж бэхжих байх” хэмээн тайлбарлажээ.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019-03-13

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт түлш шатах тослох материал нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: ДГАНЭ/201903002

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэг эрх бүхий тендерт оролцогчдоос **Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт түлш шатах тослох материал нийлүүлэх**-ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: **1. Борлуулалтын хэмжээ:** 2018 оны Борлуулалтын орлогын сүүлийнх нь санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас багагүй **2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь санал болгож буй үнийн 30 хувиас багагүй **3. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** 2018, 2017 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг ирүүлнэ. **Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Шаардахгүй **Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:** Шаардахгүй Тендерийн хамт **1,013,124 төгрөгийн** дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Тендерийг **2019 оны 04-р сарын 12 -ны өдрийн 10 цаг 30 минут-аас өмнө** доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 04-р сарын 12 -ны өдрийн 11 цаг 00 минут-т** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **Эрхгүй**
Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол, Дорноговь, Сайншанд сум, 2-р баг , Энхтайван, Утас: 70522581, Веб хаяг: tender.gov.mn

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019-03-13

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: ДГАНЭ/201903001

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэг эрх бүхий тендерт оролцогчдоос Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер -ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: **Борлуулалтын хэмжээ:** 2018 оны Борлуулалтын орлогын сүүлийнх нь санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас багагүй **Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь санал болгож буй үнийн 30 хувиас багагүй **Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** 2018 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг ирүүлнэ. **Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Шаардахгүй **Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:** Шаардахгүй **Тендерийн хамт 2,034,000 төгрөгийн** дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. **1. “Хүнсний ногоо” - 268,890 дүнтэй тендерийн баталгаа ирүүлэх** **2. “Мах, махан бүтээгдэхүүн” - 889,660 дүнтэй тендерийн баталгаа ирүүлэх** **3. “Сүү, сүүн бүтээгдэхүүн” - 307,072 дүнтэй тендерийн баталгаа ирүүлэх** **4. “Жимс жимсгэнэ” - 97,000 дүнтэй тендерийн баталгаа ирүүлэх** **5. “Бусад хүнсний материал” - 471,378 дүнтэй тендерийн баталгаа ирүүлэх** Тендерийг **2019 оны 04 -р сарын 12 -ны өдрийн 10 цаг 00 минут-аас өмнө** доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 04 -р сарын 12 -ны өдрийн 10 цаг 30 минут-т** нээнэ. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **Эрхгүй**
Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй**
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. **Монгол, Дорноговь, Сайншанд сум, 2-р баг, Энхтайван, Утас: 70522581, Веб хаяг: tender.gov.mn**

Эдийн засаг

ТӨСӨВ

Төсвийн хөрөнгөөр лити агуулсан талбайг судалж, ялгах хэрэгтэй

Монгол орны хувьд кобальтын орд байхгүй, геологийн нөхцөл байдлаар ч үүсэх боломжгүй

Т.Элиса
Шинжээч

Дэлхий даяар өндөр технологийн хөгжлийн хурдыг дагаад, түүнд шаардлагатай газрын ховор элемент, лити, кобальт зэрэг металлын эрэлт ихэссэн. Сүүлийн таван жилд л гэхэд литийн хэрэгцээ хоёр дахин өссөн. 2050 он гэхэд лити болон кобальтын эрэлт 25 дахин өснө гэсэн судалгаа бий. Монголд энэ төрлийн ховор металлын хайгуул, судалгааны ажил ямар шатанд байгаа талаар Монголын үйлдвэрлэлийн геологичдын холбооны гишүүн Д.Бат-Эрдэнэтэй ярилцлаа.

-Монгол Улсад литийн хайгуул ямар шатандаа байгаа, шинэ хөрөнгө оруулалт хэр орж ирж байгаа талаар ярилцлагаа эхлэе?

-Литийн судалгаа Монгол оронд социализмын үед эхэлж байсан ч нэгдсэн тайлан байдаггүй. Харин одоо том хэмжээний судалгааны ажил хувийн компаниуд гүйцэтгэж байна. Дундговь аймгийн нутагт эртний нуурын шавар лититэй байдаг. Мөн чулуунд илэрсэн илэрц бий.

-Манай улсад литийн томоохон орд байх боломж бий юу?

-Өнөөдөр Аргентин, Болив, Чили, Хятад зэрэг улс томоохон ордтой, лити олборлолтоороо дэлхийд дээгүүрт ордог. Хэт их давсархаг эртний нууруудын сав газарт лити элбэг тохиолддог. Эдгээр улсуудын эртний нуурын орчмоос литийн 60 хувийг олборлож ирсэн. Монголд ийм төрлийн ордын хайгуул явуулж байгаа боловч хараахан олдоогүй байна. Эртний шаварлаг ордоос литийг ялгаж авахад хүндрэлтэй байдаг л даа.

Үүнээс гадна чулуунд байдаг үндсэн орд гэж бий. Монгол Улсад ийм чулуун орд хэд хэдэн газар бий. Гэхдээ судалгааны түвшинд байгаа учир том орд болох эсэх нь мэдэгдээгүй байна.

-УУХҮ-ийн сайд PDAC-д оролцохдоо газрын ховор элементийн хайгуулаа идэвхжүүлмээр байна гэдгээ хэлсэн. Гадны улсуудаас манайд энэ



ЗГМӨ

төрлийн хайгуулд хамтрах санал ирдэг үү?

-Лити бол газрын ховор элементэд ордоггүй. Америк, Хятад зэрэг улсын олон компани литийг судалъя гэсэн санал тавьдаг. Харамсалтай нь манай геологийн судалгаа литийн түвшинд хангалттай биш учраас бидэнд үзүүлэх зүйл байдаггүй. Тэгэхээр улс тодорхой хөрөнгө зараад лити бүхий талбайг ялгаж, судалж, зааж өгвөл хөрөнгө оруулагчдад илүү дөхөм болох юм.

-Литийн онцлог юу вэ. Олборлоход хэр хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг юм бол?

-Дээр хэлсэн, эртний шавраас литийг ялгаж авахад хэцүү. Учир нь бүр ионы түвшинд орчихсон байдаг. Харин чулуун орд байвал бид өөрсдөө хайгуул, олборлолт бүгдийг чадна. Хамгийн гол нь бид цэвэр лити гаргах уу, эсвэл уламжлалтаар баяжмал гаргах уу гэдгээс шалтгаалж хөрөнгө, зардал яригдана. Мэдээж эцсийн бүтээгдэхүүн гаргаж чадвал илүү үнэтэй л зарагдана. Гэвч манайд технологи болоод боловсон хүчний нөөц байхгүй.

-Сүүлийн жилүүдэд эрэлт эрс нэмэгдэж байгаа эдгээр ховор металлуудын цаашдын чиг хандлагыг та хэрхэн харж байна?

-Гар утас, компьютер, цахилгаан машин зэргийн батерейд лити орсноор ажиллах хугацааг нь уртасгадаг. Тиймээс дэлхий даяар литийн “бүүм” эхэлчихсэн. Мөн литийг орлох ямар элемент байж болох судалгаануудыг хийж байна.

Түүний нэг нь кобальт юм.

-Кобальт зэрэг орлох металл нь Монголд хэр элбэг тархацтай вэ?

-Ерөнхийдөө шинэ технологийг дагаад шинэ ашигт малтмалын эрэлт их болж байна. Кобальт бол дэлхийд маш ховор шүү дээ. 2017 онд 110 мянган тонныг металлаар нь олборлосноос 64 мянган тонныг дан ганц ардчилсан Конго улсаас гаргаж авсан байна. Дангаараа кобальтын орд ховор, ихэвчлэн зэс, никель зэргийн дайвар маягаар олборлодог. Монгол орны хувьд кобальтын орд байхгүй, геологийн нөхцөл байдлаар ч үүсэх боломжгүй.

Аргентин, Болив, Чили, Хятад лити олборлолтоороо дэлхийд дээгүүрт ордог

-Энэ төрлийн хайгуулд хамтрах санал гадны улсуудаас тавьдаг. Тухайлбал БНСУ-аас “Эрдэнэс Монгол” ХХК-тай хамтрах асуудлаар тохиролцоонд хүрч байсан. Гэвч яагаад хайгуулаа эхлэхгүй удаад байдаг юм бол?

-Үүнийг би шууд хэлж мэдэхгүй. “Эрдэнэс Монгол” ХХК олон компанитай нэгдэж, үйл ажиллагаа эхэлнэ гэж байсан ч өнөөдрийг хүртэл чимээгүй байна. Кобальтын

хувьд ч лититэй адилхан. Эхлээд Монгол орондоо судлаад, ирээдүй бүхий талбайнуудыг тусгаарлан зааж өгвөл гадны том компаниуд сонирхоно. Тухайлбал, “тэр аймгийн тийм суманд 5000 га-д ирээдүй бүхий талбай байна, үүн дээр ажиллая” гэх юм бол хөрөнгө оруулагчид ирнэ.

-Ховор металлын салбарыг хөгжүүлнэ гэж салбарын сайд онцолж байгаа шүү дээ. Монголд ийм боломж бий юу?

-Байгаа. Сая гэхэд л газрын ховор элементийн Халзан бүргэдэй гэдэг орд дээр Германы Ааханы Их сургууль болон Монголын тал хамтран судалгаа хийсэн. Тэдний судалгааны үр дүнд Халзан бүргэдэйгээс газрын ховор элементийг ялгаж болно гэдгийг нотолсон. Газрын ховор элементийн хэд хэдэн орд Монгол оронд байдгаас хамгийн том нь энэ Халзан бүргэдэй л дээ. Бусад ордод нэгдсэн судалгаа улсын төсвөөр хийгдэж байгаа, энэ жил дүн нь эцэслэн гарах байх. Бусад өндөр технологийн лити, кобальт зэрэг элементийн хувьд 3-4 жилийн хугацаанд хийх, эрдэм шинжилгээний түвшний судалгаа хийх шаардлагатай байна.

-Үүнээс гадна цаг үеийн чухал асуудлаар таны байр суурийг сонсмоор байна. Саяхан уурхайд осол гарлаа. Ер нь уулын ажлын болон байгаль орчны нөхцлийн судалгаа төлөвлөгөөний дагуу явж чаддаг уу. Үүнд хэн хяналт тавих ёстой вэ?

-Монгол Улсад стандартын

шаардлага хангасан баримт бичгийг холбогдох байгууллагууд хэлэлцэж батлаад явдаг. Харамсалтай нь эдийн засгийн хэмнэлтийн үүднээс карьерийн налууг 50 градус байхыг 60 градус болгон босоо хийх маягаар зөрчигддөг. Ялангуяа 70-80 метрийн гүнтэй шороон ордод нурах магадлал маш өндөр. Инженер геологийн судалгааг сайн хийдэг боловч, хэрэгжүүлэхэд хяналт тавьж чаддаггүйн улмаас нуралт, гулсалт үүсч байгаа юм. Мэргэжлийн хяналтаас тэр олон уурхайд хяналт тавихад хүндрэлтэй байдаг байх.

-Стандарт нь дэлхийн жишигт нийцсэн байдаг уу?

-Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой асуудал учраас дэлхийн стандарттай нийцэж л таарна. Гэхдээ шороон орд дэлхий дахинаа багассан, Монголд түгээмэл байдаг болохоор зөвхөн манайд осол гардаг мэтээр ойлгогдож магадгүй.

-Дэлхийд ямар шинэ чиг хандлага ажиглагдаж байна вэ?

-Олборлолтын хажуугаар байгаль орчны балансыг барих шинэ стандарт мөрдөгдөж эхэлсэн. Агаар, ус, хөрсөө бохирдуулахгүй шинэ технологи ашиглах тал дээр ISO хийгдчихсэн. Бид Германы эрдэмтэдтэй хамтарч ажиллаж байхад үүнийг чухалчилж байна лээ. Олборлолт, ашиглалтаа хийхдээ эдгээр зүйлийг заавал тооцдог шүү гэдгийг бидэнд хэлж өгсөн. Манай улсад удахгүй төрийн байгууллагын албан ёсны стандартад дэлхийн жишгийг шингээх байх. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» АРИЛЖАА

Монголын хөрөнгийн бирж лхагва гарагийн үнэт цаасны арилжаагаар 26 компанийн 202,278,502 төгрөгийн үнийн дүн бүхий 842,771 ширхэг хувьцаа арилжааллаа. Үүнээс есөн компанийн хувьцааны ханш өсөж, 16 компанийнх буурсан байна. Энэ өдөр “Монгол нэхмэл” болон “Хөх ган” компанийн хувьцааны ханш хамгийн өндөр өсөлттэй байв.

» ИНДЕКС

0.82

Хувь. Топ 20 индекс 0.82 хувиар буурч, 20798.66 нэгжид хүрсэн бол зах зээлийн үнэлгээ 2.48 их наяд төгрөг боллоо.

» ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

33.9

Мянга. Улсын хэмжээнд энэ оны хоёрдугаар сарын байдлаар хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн 33.9 мянган иргэн байна. Үүний 70.7 хувь нь бүртгэлтэй ажилгүй иргэд бол үлдсэн хувь нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

» МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

3.7

Их наяд төгрөг. Мөнгөний нийлүүлэлт өнгөрсөн сард 19.6 их наяд төгрөг болж, өмнөх нэгдүгээр сараас 60.7 тэрбум төгрөгөөр буурчээ. Энэ нь 2018 оны мөн үетэй харьцуулахад 3.7 их наяд төгрөгөөр өссөн байна.

» БАНК, САНХҮҮ

3.2

Хувь. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл энэ оны хоёрдугаар сарын эцэст 1.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 3.2 хувиар өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.7 хувийг эзэлж, 2018 оны мөн үеэс 1.7 нэгжээр өсжээ.

» ТӨСӨВ

302.1

Тэрбум төгрөг. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 302.1 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

» ГАДААД ӨР

22.4

Их наяд төгрөг. Засгийн газрын нийт өр 2018 оны эцэст 22.4 их наяд төгрөг болж, 2018 оноос 390.1 тэрбум төгрөг буюу 1.7 хувиар буурсан байна.

» ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

125.3

Сая ам.доллар. Төлбөрийн тэнцэл энэ оны хоёрдугаар сард 125.3 сая ам.долларын алдагдалтай гарчээ.

ВАЛҮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,632.80
Евро	2,965.98
Японы иен	23.64
ОХУ-ын рубль	40.07
БНХАУ-ын юань	392.24
БНСУ-ын вон	2.33

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын 80 орчим хувийнх нь хувьцааны төвлөрөл өндөр байна

Б.Дөлгөөнзул
Шинжээч

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 197 компанийн 39-ийнх нь 25-аас илүү хувийг жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын 80 орчим хувийнх нь хувьцааны төвлөрөл өндөр байгаа юм. 2017 оноос хойш дотоодын хөрөнгийн захад шинээр орж ирсэн компаниуд 25-аас дээш хувиа олон нийтэд санал болгож байгаа юм. Ингэснээр олон улсын жишиг дотоодын захад нэвтэрч, бүртгэлтэй компаниудын төвлөрлийг бууруулахад дэмжлэг болсон байна. Тухайлбал, АПУ, “Говь”, “Хөвсгөл Алтан Дуулга” зэрэг компани сүүлийн жилүүдэд төвлөрлөө бууруулахаар зарим нь хувьцаагаа хувааж, зарим нь



С.Батсайхан / ЗГМӨ

нэмж хувьцаа гаргажээ.

АПУ компанийн хувьд өнгөрсөн хугацаанд хувьцаагаа хоёр удаа хуваасан юм. Ингэснээр тус компанийн олон нийтийн эзэмших хувь 6.3-аас 8.7 болж нэг жилийн хугацаанд

хоёр нэгж хувиар өссөн байна. Мөн тус компанийн том хувьцаа эзэмшигчид хувьцаагаа эргэлтэд оруулдаг нь гаднын хөрөнгө оруулагчдыг татах үндэс болдог гэж шинжээчид үзэж байна. Учир нь гаднын хөрөнгө оруулагчид

хувьцааны төвлөрөл өндөр компаниудыг сонирхох хандлага бага байдаг аж.

Хувьцаагаа хувааснаар хувьцааны төвлөрөл нь буурч байгаа компаниудын жишээ хэд хэд байгаа ч том хувьцаа эзэмшигчид нийлүүлэлт хийхгүй тохиолдолд төвлөрөл буурах боломжгүй гэдгийг зарим компанийн жишээнээс харж болохоор байна. Тухайлбал, “Говь” компани төвлөрлөө бууруулж, хөрвөх чадвараа нэмэгдүүлэхээр 2018 оны эцэст нэгж хувьцаагаа 100 хуваасан юм. Хэдий тийм боловч тус компанийн жижиг хувьцаа эзэмшигчдийн мэдэлд байгаа хувь хэмжээ өнгөрсөн хугацаанд өөрчлөгдөөгүй байна.

Харин Монголын хөрөнгийн биржийн II ангилалд бүртгэлтэй “Хөвсгөл Алтан Дуулга” компани 2018 онд нэмж хувьцаа гаргах

замаар төвлөрлөө бууруулж, хөрвөх чадвараа сайжруулсан аж. Тодруулбал, нэмж хувьцаа гаргасны дараа тус компанийн 25-аас дээш хувийг олон нийт эзэмших болсон байна. Мөн арилжааны идэвх нь эрс нэмэгдэж, жилд нэг ч удаа арилжихгүй тохиолдлууд байсан тус компанийн хувьцаа нэмж хувьцаа гаргаснаас хойш тогтмол арилжиж, зарим үед идэвхээрээ тэргүүлсээр байна. Цаашид бүртгэлтэй компаниудын төвлөрлийг бууруулах шаардлагатай гэж Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороо үзэж байна. Энэ хүрээнд бирж төвлөрөл нь 90 хувиас дээш компаниудад үүргээ биелүүлэн ажиллах шаардлагыг 2019 оны сүүлийн хагасаас эхлэн хургүүлнэ гэж мэдээлээд байгаа юм.

